



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ЭДИЙН ЗАСГИЙН БОЛОН ҮЙЛДВЭРЖИЛТИЙН
БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН
ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**ЭДИЙН ЗАСГИЙН БОЛОН ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4-40

<i>1. “Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.04.14-ний өдөр өргөн мэдүүлсэн/</i>	4-40
--	------

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн болон Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороодын
04 дүгээр сарын 19-ний өдөр /Лхагва гараг/-ийн хамтарсан
хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хамтарсан хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 53.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 23 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: А.Адъяасүрэн, Б.Жавхлан, Ч.Хүрэлбаатар, Г.Тэмүүлэн, Ж.Эрдэнэбат;

Чөлөөтэй: Х.Ганхуяг, Т.Доржханд, Г.Амартүвшин;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Ганбаатар, Н.Ганибал, Ч.Ундрэм, Г.Дамдинням, Д.Өнөрболор.

Нэг. “Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.04.14-ний өдөр өргөн мэдүүлсэн/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийг төлөөлөх эрх бүхий Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбат, “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн Өмнөговь аймаг дахь уурхайн салбарын захирал Л.Доржсүрэн, мөн компанийн Хууль, эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал, Худалдан авах ажиллагааны газрын дарга Н.Цэрэнсамбуу, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Г.Гантулга, Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын захирал Х.Мөнхжаргал, Стратеги төлөвлөлт, төслийн газрын дарга Ц.Анх-Од, Маркетинг, борлуулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Булган нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, М.Оюунчимэг, Б.Баттөмөр, Ц.Анандбазар, Ж.Батжаргал, С.Ганбаатар, Т.Энхтүвшин, Д.Батлут, Г.Ганболд, О.Цогтгэрэл нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийг төлөөлөх эрх бүхий Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбат, “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн Худалдан авах ажиллагааны газрын дарга Н.Цэрэнсамбуу нар хариулж, тайлбар хийв.

Ц.Цэрэнпунцаг: Монгол Улсын Засгийн газраас ирүүлсэн “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанид тогтоосон онцгой дэглэмийн хугацааг сунгах саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	6
Бүгд:	19

68.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсгийг үндэслэн Байнгын хорооноос боловсруулсан “Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүн, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга Т.Энхтүвшин танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Цэрэнпунцаг: “Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжэе гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 8
Бүгд: 19
57.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 04 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 42 минут үргэлжилж, 32 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 59.4 хувийн ирцтэйгээр 13 цаг 05 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Т.ЭНХТҮВШИН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр,
Лхагва гараг
Төрийн ордны “Их эзэн Чингис хаан”
танхим
11 цаг 23 минут

**БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ**

Ц.Цэрэнпунцаг: Байнгын хороодын хороодын эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Ингээд хуралдаанд оролцож байгаа гишүүдээ танилцуулъя.

Ж.Ганбаатар гишүүн өвчтэй, Н.Ганибал гишүүн өвчтэй, Х.Ганхуяг гишүүн чөлөөтэй, Т.Доржханд гишүүн чөлөөтэй, Б.Жавхлан гишүүн гадаадад томилолттой, Ч.Ундрам гишүүн өвчтэй, Ч.Хүрэлбаатар гишүүн гадаадад томилолттой, Г.Амартүвшин чөлөөтэй, А.Адьяасүрэн гишүүн орон нутагт ажиллаж байна. Г.Дамдинням гишүүн чөлөөтэй, Д.Өнөрболор гишүүн өвчтэй, Г.Тэмүүлэн гишүүн орон нутагт ажиллаж байна. Ж.Эрдэнэбат гишүүн орон нутагт ажиллаж байгаа юм байна.

Ингээд бусад гишүүд ирж, хуралдааны ирц 53.1 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хороо болон Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн хамтарсан хуралдаан нээснийг мэдэгдье.

Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хэлэлцэх нэг асуудал байгаа.

“Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанид тогтоосон онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай асуудал.

Засгийн газар 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд саналаа ирүүлсэн.

Ингээд хэлэлцэх асуудалтай холбоотой өөр саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа орьё.

“Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанид тогтоосон онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай асуудлыг хэлэлцэж эхэлье.

Засгийн газраас ирүүлсэн саналыг уншиж танилцуулъя.

Санал хүргүүлэх тухай.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газарт эрх олгох тухай хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанид 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдөр тогтоосон онцгой дэглэмийн хугацааг сунгах саналыг хүргүүлж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93.1-д заасны дагуу Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан.

Онцгой дэглэмийн хугацааг сунгах талаарх танилцуулгыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан танилцуулна.

Ажлын хэсгийн 2 номерын микрофоныг нээе. Ажлын хэсгийн 2 дугаар микрофоныг нээе дээ.

Д.Амарбаясгалан: Эрхэм Улсын Их Хурлын Байнгын хорооны дарга, гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, экспортыг эрчим хэрэгжүүлэх зорилгоор “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанид 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн 6 сарын хугацаагаар онцгой дэглэм тогтоож, Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгчийг томилон ажиллуулж байна.

Онцгой дэглэм тогтоох үед “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн санхүүгийн нөхцөл байдал хүнд, үйл ажиллагаа ил тод бус, санхүүжүүлж буй төсөл, хөтөлбөртэй холбоотой мэдээллийг нууцад хамааруулсан, ажлын гүйцэтгэл хоцрогдолтой байсан.

Түүнчлэн “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, шаардлагагүй алба, нэгжийг татан буулгах, ажилчдын сахилга, хариуцлагыг сайжруулах зайлшгүй шаардлагатай байсан.

“Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн онцгой бүрэн эрхт төлөөлөгч нүүрс олборлолт, тээвэрлэлтийг оновчтой зохион байгуулах, борлуулалт, экспортыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангуулах, нүүрсийг хил

нөхцөлөөр биржээр арилжих, шаардлагатай төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэн тодорхой үр дүнд хүрээд байна. Тухайлбал, нүүрсийг биржээр хил нөхцөлөөр борлуулж, нүүрсний үнэ, борлуулалтыг нэмэгдүүлсэн.

Нүүрс тээврийн зохион байгуулалтыг сайжруулж, тээврийн компаниудын үйл ажиллагааг дэмжсэнээр тэдний төсөвт төлөх татварын хэмжээ нэмэгдсэн.

Компанийн тусгай зөвшөөрлийн талбайгаас нүүрс дутсан асуудлыг эцэслэн шийдвэрлэсэн.

Нүүрс худалдах, худалдан авах гэрээний нөхцөлийг өөрчлөн уурхайн ам нөхцөлөөс хил нөхцөлд шилжүүлсэн.

Уулын ажлын гүйцэтгэх зардлыг бууруулсан.

Компанийн өр төлбөрийг барагдуулж ашигт ажиллагааг нэмэгдүүлсэн.

Ил тод байдлыг хангах үүднээс нууцад хамааруулсан төслийн гэрээнүүдийг ил тод болгосон.

Төслүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлсэн.

Компанийн бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох ажлын хүрээнд шаардлагагүй алба, нэгждийг татан буулгаж, удирдах ажилтны тоог бууруулсан.

Хууль зөрчсөн байж болзошгүй тохиолдлуудыг хянан хяналт шалгалтын байгууллагуудад гомдол гарган

шилжүүлсэн зэрэг үр дүнгүүд гарч эхлээд байна.

Онцгой дэглэмийн хугацаа хугацаанд 1 тэрбум 260.6 сая ам.долларын үнэлгээтэй 13 сая тонн нүүрс борлуулсан нь “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн түүхэн дээд амжилт болсон ба энэ нь 2022 оны борлуулалтын орлогын дүнгээс илүү байгааг дурдах нь зүйтэй.

Түүнчлэн онцгой дэглэмийн хугацаанд сарын дундаж үйлдвэрлэл, эдийн засгийн үзүүлэлт түүний өмнөх үетэй харьцуулахад эрс сайжирсан.

Борлуулсан нүүрсний хэмжээ 4.1 дахин, тээвэр 3.9 дахин, экспорт 2 дахин, орлого 3.9 дахин, олборлолт 2.7 дахин тус тус өссөн байна.

Компанийн 500 сая ам.доллароос багагүй орлого олж гадаад валютын нөөц нэмэгдүүлэх үүргийг давуулан биелүүлж, 588 сая ам.долларын орлогыг олж, 416.6 сая ам.долларыг Монголбанканд тушаасан байна.

Тус компанийн хувьд өнгөрсөн 2022 онд компанийн түүхэн дэх хамгийн өндөр орлого, ашигтай ажилласан жил болж цэвэр ашиг нь 1.3 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд энэ оны эхнээс 03 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд 765.2 сая ам.долларын үнэлгээтэй 7.5 сая тонн нүүрс борлуулж, үүнээс 445.6 сая ам.долларыг дансанд төвлөрүүлж, бондын 120 орчим сая ам.долларын үнэт үндсэн болон хүүгийн эргэн төлөлтийг үйл ажиллагааны орлогоор төлөх боломжийг бүрдүүлэн худалдан авагчдад төлөх өр төлбөрийг 169.2 сая ам.доллороор бууруулсан байна.

Нийт 7 удаагийн биржийн арилжааг амжилттай зохион байгуулж,

224 мянган тонн коксжих нүүрс, 192 мянган тонн эрчим хүчний нүүрс, нийт 416 мянган тонн нүүрсийг биржээр хил нөхцөлөөр амжилттай борлуулж, нүүрс олборлохоос экспортлох үе шатыг ил тод болгон төсөвт төвлөрүүлэх татвар, хураамжийн төлөвлөгөөг 1.6 дахин буюу 470.5 орчим тэрбум төгрөгөөр давуулан биелүүлсэн.

Тээврийн тендерийг амжилттай зохион байгуулж “Си” зөвшөөрөл олгох үйл ажиллагааг ил тод болгож, нүүрсийг хил хүртэл тээвэрлэх, борлуулах бэлтгэлийг хангуулж, биржээр борлуулсан нүүрсийг 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрөөс Ганцмод боомтод хүргэж эхэлсэн байна.

“Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанид тогтоосон онцгой дэглэмийн үед шаардлагатай арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр компанийн санхүүгийн нөхцөл байдал сайжирч, гадаад валютын орох урсгал нэмэгдсэн хэдий ч Тавантолгойн нүүрсний ордын эдийн засгийн өгөөж, үр ашгийг сайжруулах, нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлэх нүүрсний олборлолт, тээвэрлэлт, борлуулалт, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг бий болгох, өртөг зардлыг бууруулах, нээлттэй ил тод байдлыг хангуулах, нүүрсийг хил нөхцөлөөр биржээр арилжих зэрэг үйл ажиллагааг жигдрүүлэх, тогтвортой хадгалах, цаашид улам сайжруулж, үүссэн нөхцөл байдлыг бүрэн арилгах үүднээс “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанид тогтоосон онцгой дэглэмийн хугацааг сунгах зайлшгүй шаардлагатай байна.

“Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанид тогтоосон онцгой дэглэмийн хугацаанд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн, цаашид авах арга хэмжээний

талаар танилцуулгад дэлгэрэнгүй дурдсан байгаа.

Иймд “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанид тогтоосон онцгой дэглэмийн хугацааг сунгах саналыг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93.1-д заасны дагуу хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Д.Амарбаясгалан сайд баярлалаа.

Ингээд ажлын хэсгийг танилцуулъя. Ж.Ганбат “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийг төлөөлөх эрх бүхий Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч, Л.Доржсүрэн “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн Өмнөговь аймаг дахь уурхайн салбарын захирал, Э.Түвшинжаргал “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн Хууль эрх зүйн газрын дарга, Н.Цэрэнсамбуу тус компанийн Худалдан авах ажиллагааны газрын дарга, Г.Гантулга тус компанийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Х.Мөнхжаргал тус компанийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын захирал, Ц.Анх-Од тус компанийн Стратеги төлөвлөлт, төслийн газрын дарга, Б.Булган тус компанийн Маркетинг, борлуулалтын хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч.

Онцгой дэглэмийн хугацааг сунгах талаар Засгийн газраас ирүүлсэн саналтай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү.

С.Ганбаатар гишүүнээр тасаллаа. Д.Батлут гишүүнээр тасаллаа. Б.Энхбаяр гишүүн асуултаа асууя.

Б.Энхбаяр: Баярлалаа.

Тэгэхээр Монгол Улс чөлөөт зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжиж шинэ ардчилсан Үндсэн хуулиа батлаад 31 жил болж байна.

Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсантай холбоотойгоор шинэ Үндсэн хуульд нийцээгүй хуулийг хүчингүй болгох, шинэ Үндсэн хуульд нийцсэн хууль тогтоомжийг батлах энэ эрх зүйн шинэтгэлийн үйл ажиллагаа тасралтгүй явагдаж байгаа.

Нэг зарчим байдаг нь Монгол Улс Үндсэн хуульдаа нийцээгүй ийм олон улсын гэрээ, хууль тогтоомж мөрдөхгүй гэдэг ийм л зарчим байдаг.

Тэгэхээр шинэ Үндсэн хуулиас өмнө батлагдсан бөгөөд одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа 2 хууль, 1 олон улсын гэрээ байгаад байгаа юм.

Нэг нь, энэ онцгой дэглэм тогтоохтой холбоотой 1991 оны Бүгд Найрамдах Монгол Ард Улсын нэг хууль.

Хоёрдугаарт, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын үйлдвэрчний эвлэлийн байгууллагуудын тухай хууль. Бас 1991 оны хууль.

Дараа нь Үндсэн хуулиас өмнө гарсан Улаанбаатар төмөр замын хувь нийлүүлсэн гэрээ хүчин төгөлдөр үйлчлээд байгаа юм.

Тэгэхээр энэ Үндсэн хуульд нийцэж байгаа хууль мөн үү, үгүй юу гэдэг асуудлыг би өмнөх хуралдаан дээр бас асууж байсан.

Эдийн засгийн байнгын хорооны өмнөх хурал дээр.

Одоо бид энэ ямар хуулийн заалтыг иш болгож сунгах гээд байна вэ гэхээр үйлдвэрийн газар, байгууллагад тогтоосон онцгой дэглэм, түүний хэрэгжилтийн явцыг сар бүр Улсын Бага Хурал олон түмэнд мэдээлж байх. Тухайн үйлдвэрийн газар, байгууллагад онцгой дэглэм тогтоосон нөхцөл байдал арилаагүй бол хугацааг нь сунгах тухай саналаа уг хугацаа дуусахаас 10 хоногийн өмнө Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Бага Хуралд оруулж байхыг Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газарт даалгасугай.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Бага Хурал нь зайлшгүй шаардлагатай гэж үзвэл онцгой дэглэмийг нэг удаа 6 сар хүртэл хугацаагаар сунгаж болно гэсэн энэ заалтаар бид сунгах гээд суугаад байгаа юм.

Тэгэхээр Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Бага Хурал 30 жилийн өмнө байхгүй болчихсон.

1992 оноос хойш 30 жил Улсын Их Хурал гэж л байгаа.

Тэгэхээр Улсын Их Хурал энэ Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Бага Хурал юм гэж ойлгож байгааг ямар хууль зүйн учир шалтгаанаар ойлгож бид шийдвэр гаргах гээд байна вэ?

Би бол Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Бага Хурлын гишүүн биш. Би бол.

Тийм учраас би санал өгөхдөө эхлээд хуулийн асуудлыг нь тодорхой болгож байж өөрийнхөө саналыг дараа нь илэрхийлье гэсэн ийм бодолтой байгаад байгаа юм.

Ц.Цэрэнпунцаг: Засгийн газраас энэ хуулийг хэрэглэх хууль зүйн үндэслэлээ тайлбарлаж өгөх үү? Д.Амарбаясгалан сайдын микрофоныг. 2 номер. Ажлын хэсэг.

Д.Амарбаясгалан: Өнөөдөр Монгол Улсад 1992 оноос өмнө батлагдсан хэд хэдэн хууль зохицуулалт хийж байгаа.

Тэгэхээр эдгээр хуулиудыг шинэчлэн найруулах, өнөөдрийн нийгмийн амьдралын хэрэгцээ шаардлагад нийцүүлэх ийм зохицуулалтыг хийх зайлшгүй шаардлага тулгамдсан байгаа гэдэгтэй санал нэг байгаа.

Засгийн газрын зүгээс өнөөдөр яг хэрэгжиж байгаа хуулийнх нь хүрээнд, мөн Үндсэн хуульд нийцсэн тодорхой шийдвэрүүдийг гаргуулах зорилготойгоор Улсын Их Хуралд саналаа тавьсан гэдгийг бас хэлмээр байна.

Үндсэн хуулийн цэцийн болон холбогдох хуулийн мэргэжлийн нарийн судлаач нартай энэ талаар өмнө нь ч бас санал солилцож, энэ хууль өнөөдөр яг зохицуулалт хийх бүрэн чадамжтай эсэх тал дээр судалгаа, дүгнэлтүүдийг гаргуулж авч байсан.

Мэдээж Үндсэн хуулийн өмнө батлагдах, дараа батлагдах гэдэг нэг харах ёстой өнцөг боловч нөгөө талаараа Монгол Улсад батлагдаад хэрэгжээд явж байгаа хууль нь өөрөө хүчингүй болоогүй тохиолдолд хэрэгжих бүрэн боломжтой юм гэдэг энэ асуудал яригдаад явж байгаа.

Энэ бүрэн эрхт төлөөлөгчийн хугацааг сунгаж ажиллуулах зайлшгүй шаардлага үүссэнтэй холбогдуулж

Засгийн газраас Улсын Их Хуралд ирүүлсэн санал.

Мөн энэ саналыг гаргахдаа Монгол Улсын Ерөнхий сайдаас Хууль зүйн сайдад хуулийн шинэчилсэн найруулгыг хийж, Улсын Их Хуралд өргөн барьж батлуулах үүрэг даалгаврыг Хууль зүйн сайдад өгсөн байгаа.

Ер нь Засгийн газрын зүгээс хэрэгжиж байгаа хуулиудын амьдралд нийцэж байгаа нийцлийг нь 3-аас 5 жил тутамд авч үздэг байх тэр институт, бүтцийг бий болгож ажиллах шаардлагатай гэж үзэж байгаа.

Ирэх оны төсвийг өргөн барихдаа Засгийн газрын тухай хуульд бас нэмэлт, өөрчлөлтийг оруулж тодорхой үүрэг чиглэл бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийг бий болгох зорилгыг агуулж байна.

Хөгжилтэй улс орнуудын жишээг харахад ер нь 3-аас 5 жилийн хугацаанд хуулийн нийцлийг амьдралд хэрэгжүүлэх энэ алхмыг иргэн, төр, хувийн хэвшилтэйгээ хамтарч тогтмол хийдэг нь маш чухал үүрэг байна гэж хардаг.

Засгийн газрын зүгээс өнгөрсөн хугацаанд Монгол Улсад хэрэгжиж байгаа 800 гаруй хуульд нэг бүрчлэн заалт, зүйл бүрээр нь хийсэн шинжилгээгээр ер нь хуульд тодорхой өөрчлөлтүүд зайлшгүй шаардлагатай юм байна.

Нэгдүгээрт, философийн хувьд өөрчлөх шаардлагатай хууль Монголд их байна.

Хоёрдугаарт, бичилтийнх нь арга барилд өөрчлөлтийг оруулах зайлшгүй шаардлага үүсэж байна.

Зах зээлийн эдийн засгийн нийгэмд шилжсэн. Хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлооход Үндсэн хуулийн оршил хэсэгтээ тусгасан ийм улсын хувьд хуулийн бичилтийн хэлбэр нь хүртэл эхлэхдээ Улсын Их Хурал, Засгийн газар, эрх бүхий байгууллагад эрх олгож эхэлдгээсээ илүү иргэн, аж ахуйн нэгждээ боломжийг бий болгох, тэдний эрх ашгийг хамгаалсан агуулга, философийг тусгаж явах нь зайлшгүй шаардлагатай юм байна гэж үзэж байна.

Нөгөө талаар сая Б.Энхбаяр гишүүний асуудагтай адилхан хуучны хуулиуд нь өнөөдрийнхөө нийгмийг бүрэн дүүрэн зохицуулж чадахгүй байгаа, хоцрогдсон байдал цаг үргэлж ажиглагддаг болсон.

Тэгэхээр энэ бүгдийг өөрчилж шинэчилж байх алхам дээр Засгийн газрын зүгээс санаачилгатай ажиллана гэдгийг бас хэлье.

Ц.Цэрэнпунцаг: М.Оюунчимэг гишүүн асуултаа асуух уу? М.Оюунчимэг гишүүн асуултаа асууя.

М.Оюунчимэг: Өглөөний мэнд.

Нөхцөл байдлын дараа 2022 оны 10 дугаар сард онцгой “БЭТ” томилсон нь зөв арга хэмжээ байсан гэдгийг хүн бүхэн мэдэж байна.

Саяын энэ санхүү, эдийн засгийн үзүүлэлтүүдийг харахад ч гэсэн орж байгаа орлогоос тодорхой харагдаж байна л даа.

Ерөнхийдөө нэг тэрбум америк долларын ямар ч байсан ашиг, бүх талын санхүүгийн тооцоонууд гарсан гээд хэлж байна. Магадгүй энэ ч гэсэн сүүлийн өдрүүдэд валютын нөөц, долларын ханш

ч бага ч гэсэн буурахад нөлөөлж байгаа болов уу гэж би харж байна л даа.

Тэгээд онцгой байдал тогтоох үед нүүрсний асуудал, санхүүгийн асуудал, төслүүдийн асуудал гээд нэлээд хүндрэлтэй асуудлууд байсан. Нүүрсийг хямдаар борлуулж байсан гэж байна. Дутсан нүүрсний асуудал гэж байна. Тээвэрлэлт, түүнээсээ олох гэж байгаа татвар сул байсан гэдэг нь энэ татвар төлөлтөөс харагдаж байна л даа.

2021 онд 29 тэрбум, 2022 онд 97 тэрбум, 2023 оны 3 сарын байдлаар 76 тэрбум төгрөгийн компаниудын төлсөн татвар гэж байна. Тээврийн компаниудын.

Эхний 3 сард ийм байгаа юм чинь тэгвэл 2023 оны хувьд энэ тээврийн компаниудын төлөх татвар илүү өндөр гарна гэж ойлгож болох уу? 100 гаруй тэрбум төгрөгөөр. Нэгдүгээрт, энэ байна.

Хоёрдугаарт, одоо энэ гадаадтай хийж байгаа нүүрсний үнэ ханшийг өндөр болгож байгаа юм чинь Та бүхэн 2023 оны оны эцсийн байдлаар яг энэ төсөвт орох, Монголбанкны валютын нөөцөд нөлөөлөх. Энэ нь өөрөө эргээд мөнгөний бодлогод нөлөөлөх тал дээр ямар ашиг, ямар тооцоо судалгаа харагдаж байгаа вэ? Эдийн засгийн үзүүлэх талаасаа.

Би үүнийг Ж.Ганбат даргаас асууя гэж бодож байна. Нэгд.

Хоёрт, энд бусад асуудал гэдэг дээр байна л даа. Шалтгаангүйгээр гэрээ байгуулаагүй компаниудыг хохироосон гэж байна. Энэ хохироосон компаниудтай буцаж гэрээ байгуулсан уу? Энд жишээ нь, ямар компаниуд байгаа юм. Манай дотоодын компаниуд уу, гаднын компаниуд уу?

Төлбөрийн баталгаагүйгээр мөнгө шилжүүлдэг байсныг зогсоосон гэж байна. Тэгээд энэ дээр ямар болов? Нөгөө оффтейк гэрээнүүдийг ил болгоно гэж хэлсэн. Гэхдээ одоо жишээлбэл үлдсэн нэг асуудал байгаа гээд энд байна л даа. Энэ гэрээтэй холбоотой нэг асуудлыг үлдээгээд байгаа гэнэ.

Тэгэхээр энэ ямар компанитай, ямар төмөр замын асуудлаар энэ гэрээ үлдсэн байгаа вэ? Энэ дээр бас нэг тодорхой хариулт өгөөч ээ гэж хүсэх байна.

Хоёр дахь зүйл нь, би бас Б.Энхбаяр гишүүний хэлээд байгаатай өмнө ч гэсэн саналаа би илэрхийлж байсан.

Д.Амарбаясгалан даргаас асууя гэж бодож байна.

Одоо яг БЭТ буюу тэнд онцгой дэглэм тогтоогоод 7 сар болж байна. 7 сарын хугацаанд энэ хэлээд байгаа онцгой байдлын үед үүссэн нөхцөл байдлуудыг засаж залруулж ихэнхийг нь арилгасан. Одоо ажил цэгцтэй хэвийн горимоор явж байгаа гэж хэвлэлийн бага хурлын үеэр Ж.Ганбат дарга мэдээлж байсан л даа.

Тэгээд одоо яагаад дахиад энэ БЭТ-ийг энэ онцгой дэглэмийг ингэж сунгаж үргэлжлүүлэх шаардлага нь юу байгаа юм бэ?

Энгийн горимоор энэ “Эрдэнэс Тавантолгой” компани ажиллаж ер нь чадахгүй байгаа юм уу, болохгүй байгаа юм уу? Эсвэл хүний нөөц олдхоггүй байгаа учраас Сангийн яам багаараа очоод энд ажиллаад байгаа юм уу?

Хяналт тавих газар нь сул байгаад байгаа юм уу? Уг нь Монголын хууль хууль л байх ёстой. Хуулиа бариад явчихвал онцгой дэглэмийг 6 сар, 7 сар тогтоогоод овоо хэвийн боллоо.

Тэгвэл одоо яг тэр арилжааны, зах зээлийн горимоор нь Эрдэнэс Тавантолгойг ажиллуулаад явчих боломж харагдахгүй байгаа юм уу? Энэ дээр нэг тодорхой хариулт өгөөч.

Дараа нь тодруулж асууя гэж бодож байна.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн 2 номер.

Д.Амарбаясгалан: М.Оюунчимэг гишүүний асуултад хариулья.

Түүрүүн танилцуулга дээр тодорхой хэлсэн байгаа. “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанид бүрэн эрхт төлөөлөгч томилоод гарсан үр дүнг цаашид жигдрүүлэх үйл ажиллагаанд хэвийн горим дээр ажиллахад ч дагаж мөрдөгддөг тэр тогтолцоонд аваачих нь Засгийн газрын эн тэргүүнд барьж байгаа зорилго.

Бидний зүгээс хоёр түвшинд судалж өнгөрсөн хугацаанд гадаад болон дотоодын байгууллагуудтай ажиллаж байгаа юм.

Нэгдүгээрт нь, олон улсын хараат бус аудитын байгууллагаар аудит хийлгэж өнгөрсөн цаг хугацаанд энэ уул уурхайн олборлолт, санхүүгийн үйл ажиллагаа, нүүрсний борлуулалтын үйл ажиллагаа зэрэг дээр нь иж бүрэн аудитын дүгнэлт гаргуулах нь нэг дэх том зорилго байгаа.

Энэ ажил бидний хүссэнчлэн 6 сарын хугацаанд бүрэн хэрэгжиж амждаг

зүйл бас биш байна. Олон улсын түвшинд нээлттэй тендер зарлаж, хараат бус компанийг оруулах. Тэр компани нь ажиллаж эдгээр бүх үйл ажиллагаанд нь нэгдсэн нэг дүгнэлт хийж гаргахад зайлшгүй цаг хугацаа орохоор болж байгаа.

Тэгэхээр бидний төсөөллөөр энэ оны сүүл гэхэд энэ аудитын дүгнэлт гарах нэг дэх нөхцөлийг бүрдүүлье.

Хоёрдугаарт, аудит хийгдсэний үндсэн дээрээс энэ байгууллагын удирдлага, менежментийн багийг гадаадын болон дотоодын хараат бус багийг бүрдүүлж сонгон шалгаруулах нөхцөлөө бүрдүүлж авах зорилгын үндсэн дээр үүнийг сунгая гэж байгаа.

Хоёрдугаарт нь, хэдийгээр Засгийн газар 6 сарын хугацаанд энэ бүрэн эрхт төлөөлөгчийг бүх талаар улс төрийн дэмжлэг үзүүлж ажиллуулсан хэдий ч цаашдаа энэ үйл ажиллагааг жигдрүүлэх шаардлага байна.

Нэгдүгээрт, Монгол талаасаа мэдээж Засгийн газрын бодлого явж байгаа бол хоёрдугаарт нөгөө харилцагч талууд. Тухайлбал, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай нүүрсний худалдаа, эргэлт, тээвэрлэлтийн зохицуулалтыг хийхэд өнөөдрийг хүртэл тулгамдаж байгаа бүрэн шийдэгдээгүй асуудлуудыг нэг мөр шийдэх ийм зорилгыг агуулж байна.

Та түүрүүн асуулаа. Тээврээс олж байгаа орлого нэмэгдсэн байна гээд. Бүрэн эрхт төлөөлөгч томилогдохоос өмнөх бүх цаг хугацаанд ер нь нийт тээвэрлэлтийн бараг 90 орчим хувь нь Бүгд Найрамдах Хятад Ард Улсын нүүрсний худалдан авдаг компаниудын өөрсдийн тээврээс хамааралтай. Татвар нь Монгол Улсад бүрэн төлөгддөггүй

байсан нөхцөлийг өнөөдөр Монголд бүрэн төлөгддөг болох нөхцөл рүү оруулж байгаа юм.

Тэгэхээр үүнийг хоёр улс харилцан ойлголцож, тохиролцсоны үндсэн дээр хийгдэх нэг том ажил.

Үүнийг дагаад Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Монгол улсын Засгийн газар хооронд яригдаж байгаа нэг чухал зүйл бол энэ нүүрсний борлуулалтын асуудлыг урт удаан хугацааны гэрээ хэлцлийг хийх энэ арга замыг эрэлхийлэх нь зүйтэй.

Үнэ тохирох биш. Жил болгон тогтмол хэчнээн сая тонн нүүрсийг аль хилийн боомтоор худалдаж авах нөхцөлтэй юм бэ гэдгээ харилцан тохиролцох нь эн тэргүүний ажил.

Үүнийг дагаад Монгол Улсын уул уурхайн компаниуд нь хөрөнгө оруулалтаа хийж, ирэх жилүүдэд нүүрсний экспортыг нэмэгдүүлэх чиглэл дээр бодлого гаргаж ажиллахад хоёр дахь асуудал нь оршоод байгаа юм.

Тэгэхээр эдгээр зүйлийг цэгцлэх зорилгоор бидний зүгээс энэ бүрэн эрхт төлөөлөгчийн хугацааг сунгах саналыг Улсын Их Хуралд дэвшүүлж байгаа юм. Тийм.

Тэгээд бусад санхүүгийн асуудал дээр Ж.Ганбат захирал хариулья.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн 3 номерын микрофоныг нээе.

Ж.Ганбат: М.Оюунчимэг гишүүний асуултад хариулья.

Бид 5 сарын хугацаанд 13 сая тонн нүүрс экспортод борлуулж чадсан. Одоо

энэ оны нэгдүгээр улиралд бид 7.5 сая тонн нүүрс.

Яг энэ эрчээрээ бид явах юм бол энэ онд 30 саяыг бид борлуулна. Бид өнгөрсөн 2022 онд 1.3 их наяд төгрөгийн татвар төлсөн. Одоо бид яг энэ эрчээрээ явбал 30 сая тонн нүүрс борлуулах юм бол 2.7 их наядын татвар ер нь төлөх юм байна гэдэг ийм тооцоог гаргаад ажиллаж байгаа.

Ер нь нөгөө талдаа “Эрдэнэс Тавантолгой” яг бүрэн хүчин чадлаараа ажиллаад явбал сард 2-оос 2.5 сая тонн нүүрс борлуулаад байхад. Тэгээд өдөрт 800-аас 1000-аад машиныг тээвэрт явуулаад байхад бид ямар нэгэн асуудалгүй яваад байх боломжийн байна гэдгийг сая энэ онцгой дэглэм тогтоосон 5 сар гаруй хугацаанд бид нотолж энэ дээрээ дүгнэлт хийж харж байгаа л даа.

Яг энэ эрчээрээ ингээд явахад.

Нөгөө талдаа бид “Эрдэнэс Тавантолгой” компани нь 12, 13 жилийн түүхтэй компани. Ер нь голцуу сайн чанарын коксожсон нүүрсээ зарж ирсэн. Бид үүнийг сорчлохгүй гэдэг юман дээр бас энэ тал руугаа бодлогоо гаргаад, үйл ажиллагаагаа чиглүүлээд ажиллаж байгаа.

Ер нь “Эрдэнэс Тавантолгой” компани цаашдынх нь уулынх нь ажлын нөхцөл ч гэсэн сул коксожсон нүүрсийг бид зарахгүй бол бас уулын нөхцөл байдал хүндэрч байгаа.

Нөгөө талдаа бид эрчим хүчний нүүрсийг бас борлуулах ёстой. Энэ хүрээндээ бид бирж дээр 200 мянган тонн эрчим хүчний нүүрсийг бид туршилтаар арилжсан. Амжилттай болсон.

Өнгөрсөн долоо хоногийн тав дахь буюу сая 04 сарын 14-нд бид сул коксожсон нүүрсээ 32 мянгыг бас туршилтын байдлаар арилжсан. Энэ амжилттай болсон.

Тэгэхээр арилжаа ингээд амжилттай болсон учраас бид энэ бүтээгдэхүүнээ зарах бүрэн боломж байна. Бид цаашдаа сорчлохгүйгээр яваад байх боломж байна гэдэг ийм дүгнэлтийг хийж байгаа.

Таны дараагийн асуусан. Яах вэ, яг онцгой дэглэм тогтоох үед энэ компани дээр санхүүгийн хувьд бас үнэхээр асуудалтай юмнууд байсан. Тендерт ялсан компани гэрээ байгуулах гэхээр гэрээг нь байгуулдаггүй. Ямар нэгэн шалтаг хэлж байгуулахгүй байж байгаад тэр тендерийг нөгөө хуулийн хугацааг нь өнгөрөөчихдөг.

Үүнээс болоод нөгөө тендерт ялсан компани хохирдог ийм байдал. Жишээ нь, “Эрдэнэс Тавантолгой” компанийн даатгалын тендер байгаа шүү дээ. Даатгалын тендер дээр нь Бодь даатгал гэж компани ялчхаад байхад гэрээг нь байгуулахгүй байсаар байгаад хугацааг нь өнгөрөөчихсөн. Тэгэнгүүт нөгөө даатгалын компани дээрээ гэрээг нь үргэлжлүүлэхээс өөр аргагүй нөхцөл байдал руу оруулдаг.

Тэгэхээр өөрийнх нь л өмнө нь байсан компанийн эрх ашгийн төлөө бас энэ компани дээр бодлого яваад байсан ийм юмнууд байна л даа.

Тэгэхээр нэгэнт хуульд заасан ном журмынхаа дагуу энэ сонгон шалгаруулалтаа явуулдаг, гэрээгээ байгуулдаг, ил тод байх. Энэ дээр нь бид үйл ажиллагаагаа засаж залруулаад явж байгаа.

Дараагийн юм нь “Эрдэнэс Тавантолгой” компани нь төрийн өмчит компани. Энэ компанийг санхүүгийн хувьд эрсдэлд оруулах ийм алхмууд явж байсан.

Компанитай гэрээ байгуулангуутаа ямар нэгэн урьдчилгаа төлбөрийн баталгаагүйгээр санхүүжилтийг нь 70 хувийг нь эд нар олгодог. Тэгээд санхүүжилтийг нь өгчхөөд мэдээж тендерт ялсан нэртэй компани байна уу, шууд гэрээ байгуулсан компани нь 70 хувийнхаа урьдчилгаа байна уу мөнгөө авчих юм бол тэр бизнес хийх нь тодорхой шүү дээ.

Тэгэхээр хэн нэгэн итгэлээр давуу байдал үүсгэдэг ийм нөхцөл байдал үүсээд байсан учраас энэ бүгдийг нь залруулаад ингээд яваад байгаа гэдэг юм.

Оффтейк гэрээтэй холбоотой. Бид ам нөхцөлтэй байсан гэрээнүүдийг ер нь бүгдийг нь хугацааг нь дуусгах бодлого барьсан.

Нийтдээ яг онцгой дэглэм тогтоох үед 178 борлуулалтын гэрээ байсан. Үүн дотроос ам нөхцөлтэй 133 гэрээ байсан. Бид өнөөдрийн байдлаар хугацаа нь болоогүй 133 ам нөхцөлтэй гэрээнээс 87 гэрээг нь бид хил нөхцөл болгож өөрчилсөн. Хил нөхцөлөөр буюу гэдэг нь биржийн үнээр зарахаар ингэж хэлцэл хийгээд ингэж зарсан. Энэ хүрээндээ бид одоо үнийн хэлбэлзлээс хамаараад.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: М.Оюунчимэг гишүүн нэмэлт асуулт асууя.

М.Оюунчимэг: Бүрэн эрхт төлөөлөгчдийн хувьд энэ санхүүгийн асуудал дээр үнэхээр бас хяналт тогтоож ингээд барьж сайжруулж чадсан нь энэ үзүүлэлтүүдээс харагдаж байна л даа.

Харин нийгэмд ингээд хүлээлт үүсгээд байгаа нөгөө дутсан нүүрс дээр янз янзын тоонууд хэлээд л. Тэгээд үүнийгээ буцааж авч чадаж байгаа юм уу, үгүй юм уу? Эсвэл зүгээр тэр хууль хүчний байгууллагад нь орхиж байгаа юм уу?

Дутсан нүүрс дээр одоо яг хэдий хэмжээний асуудал яригдаж байгаа юм? Эргэж эндээс олж авсан зүйл байгаа юу?

Хамгийн хоёр дахь нэг гол зүйл нь төлбөрийг нүүрсээр төлдөг энэ гэрээ хэлэлцээрүүдийг эрс бууруулна гээд Та бүхэн маань амлаж байсан. Одоо бол нэг томоохон хэмжээний нэг гэрээний үлдэгдэл байгаа гэж байна шүү дээ. 4.3 сая тонн гэж байна. Тийм ээ. Хугацаа нь 2024 оны 12 сарын 31-нд дуусна гээд ярьж байна.

Сая бас Улаанбаатар хотын нөгөө замын түгжрэлийг бууруулах дэд бүтэцтэй холбоотой зүйлийг Бүгд Найрамдах Хятад Ард Улстай хамтарч ажиллавал бас урьдчилаад нүүрсээр гэрээ хийх тухай асуудал хэвлэлээр яваад байсан. Яг ийм зүйл бас байгаа юу гэсэн хоёр зүйлд хариулт авъя.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн 3 номер хариульа.

Ж.Ганбат: Нөгөө орон нутгийн Тавантолгой компанитай “Эрдэнэс Тавантолгой” компанийн хооронд тусгай зөвшөөрөлтэй талбай руу хэтэрч олборлосон гэдэг ийм нэртэй тэр мөргөцөг гэдгийн асуудал ерөнхийдөө 2012 оноос эхэлж үүссэн юм билээ.

Тэгээд энэ явсаар байгаад өнгөрсөн оны 2022 оны 12 сарын 27-нд “Эрдэнэс Тавантолгой” компани орон

нутгийн Тавантолгой компанитай үүнийг эцэслэн шийдсэн байгаа.

Нийтдээ 258.9 мянган тонн нүүрсний төлбөр болох нийт 13.9 сая доллар буюу 48 тэрбум төгрөг “Эрдэнэс Тавантолгой” компанийн дансанд орон нутгийн Тавантолгойгоос бүрэн шилжүүлээд энэ мөргөцөг тойрсон асуудлыг эцэслэсэн байгаа.

Тэгэхээр одоо энэ дээр дахиж мөргөцөг дутсан асуудлууд байхгүй байгаа.

Нөгөө талдаа бид нүүрсээр төлбөр. Ер нь олборлолтын ажил хийгээд, хөрс хуулалтын ажил хийгээд л ажлынх нь төлбөрийг нь мөнгөөр өгөхгүй нүүрсээр өгдөг байсан шүү дээ. Энэ дээр тэгээд бас үнийн хөнгөлөлт.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Дараа нь гүйцээгээд хариулчхаарай. Гишүүд асуулт санал хоёр нэг явж байгаа шүү дээ.

Б.Баттөмөр гишүүн асуулт асууж, саналаа хэлье.

Б.Баттөмөр: Энэ гэрээг сунгах хугацааг дэмжиж байна. Сунгаад явах нь зүйтэй гэж бодож байна.

БЭТ томилогдох үед санхүүгийн байдал хүнд байсан. 580-аад сая долларын өр төлбөр байсан. Тэгээд дээрээс нь урьдчилаад авчихсан. 1.7 их наяд төгрөгийн өр байгаа. Аж ахуйн нэгжүүдэд олгох 123 тэрбум гээд маш их хэмжээний өр байсан л даа. Үүнийг бас зохицуулж бариад ингээд явж байгаа юм байна.

Энэ өнгөрсөн оны төгсгөлд энэ “Эрдэнэс Тавантолгой” гэдэг компани их сайн ажилласны үр дүнд Монгол Улсын

гадаад худалдааны тэнцэл 3.8 тэрбум долларын ашигтай гарсан.

Тэгээд эдийн засгийн өсөлт 4.5 хувь болоход бас нөлөөлсөн.

Энд нэг сайн үзүүлэлт бол Монгол Улсын нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 5033 доллар болсон шүү.

Энэ дээр буруу зөрүү тоонууд яваад байх шиг байна лээ. Би энэ хариуцлагатай үүнийг хэлчихье. 5033 доллар болчихсон байгаа.

Энэ бол энд нөлөөлсөн.

Манай Ж.Ганбатын хувьд маш сайн ажилласан. Төр муу менежер гэдэг юмыг бид яриад байгаа юм. Төр сайн менежер байж чадахын нэг жишээг өнөөдөр Ж.Ганбат харуулж байгаа.

13 сая тонн нүүрсийг борлуулаад 1.3 тэрбум долларын борлуулалт хийчхэж байна. Монголбанканд 800 орчим сая долларын валютын нөөц үүсгэчхэж байна шүү дээ.

Тэгээд ийм богино хугацаанд ийм боломжууд байна шүү дээ. Монголын төр энэ баялгийнхаа менежментийг зөв хийх юм бол маш их боломжууд байгаа.

Тэгээд энэ тэрийг сайн бид тооцож үзэх ёстой.

Нэгдүгээр улирлын дүн гарч байна. Нэгдүгээр улиралд чинь Монгол Улсын нийт бараа эргэлт 5.7 тэрбум доллар. Үүнээс 3.8 тэрбум нь экспорт, 1.9 нь импорт болоод зөрүү нь 1.8 тэрбум долларын ашигтай гарч байгаа юм.

Монгол Улсын төсвийн орлого 5.1 их наяд төгрөг болж байгаа. 5.1 их наяд

төгрөг гэдэг чинь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахаар 29.6 хувиар өссөн байгаа байхгүй юу. Тэгээд энэ бол юу вэ гэхээр энэ “Эрдэнэс Тавантолгой” гэдэг компанийн оруулж байгаа хувь нэмэр. Ийм сайн хувь нэмэр оруулж байна шүү дээ.

Тэгэхээр Монгол Улсын эдийн засгийн төлбөрийн тэнцэл гэж нэг мундаг том үзүүлэлт байдаг. 29 жил. Одоо сүүлийн 30 жил 29.6 тэрбум долларын алдагдалтай явж ирсэн. Гэтэл нэгдүгээр улиралд гэхэд л 656 тэрбум төгрөгийн ашигтай гарч ирж байна шүү дээ. Урсгал данс нь ашигтай. Төлбөрийн дансууд нь ашигтай ингэж гарч ирж байгаа юм.

Тэгэхээр зэрэг энэ компанийн гүйцэтгэж байгаа, энд ажиллаж байгаа хүмүүсийн үүрэг роль эдийн засагт сайн нөлөө үзүүлж байна гэдгийг би хэлэх гэж байгаа юм.

Хоёр, гурван асуултууд байна. Энэ мухар төмөр замууд дээр ямар бодлого барьж байна? Юу хийх гэж байна аа? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, эхний нэгдүгээр улирлын байдлаар нэг сая тонн нүүрс биржээр зарсан. Биржийн энэ хуулиудыг Ж.Бат-Эрдэнэ гишүүн бид нийлж гаргацгаасан.

Нэг саяыг гаргасан. Яг энэ эрчээрээ 5 саяыг л гаргах юм шиг байгаа юм. Үүнийг 10 сая, 15 сая. Гаргах нүүрснийхээ 50 хувийг биржээр зарчих ийм боломж юу байна аа? Үүнийг юу гэж харж байна аа? Засгийн газар. Д.Амарбаясгалан сайдаас асууж байгаа юм.

Тэгээд юу байгаа юм. Энэ худалдан авалт дээрээ яаж анхаарч байна. 7.5 их наяд төгрөгийн худалдан авалт

хийчихсэн. Даатгалын компаниуд 300, 400 тэрбум төгрөг өгчихсөн байгаа шүү дээ. Тийм ээ. Энэ дээрээ ямар ажлууд хийх гэж байна, яаж байна гэсэн ийм асуултуудад хариулт авъя.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсэг 3 номер эхлээд хариулж байх уу? 2 номер Ажлын хэсгийн 2 номерын микрофоныг нээе.

Д.Амарбаясгалан: Б.Баттөмөр гишүүний асуултад хариулья.

Түрүүн М.Оюунчимэг гишүүн валютын нөөцтэй холбоотой асуудлыг бас хөндөж байсан.

Яг өнөөдрийн байдлаар Засгийн газрын 362 дугаар тогтоол батлагдсаны үр дүнгээр 3.7 тэрбум валютын нөөцийг хуримтлуулсан мэдээтэй байж байгаа.

Энэ дээр бас түрүүн Б.Энхбаяр гишүүн хөндөж байгаа нь энэ 1991 оны хуулиудаар зохицуулалт хийгдэж байгаа байдал бас энэ валютын зохицуулалттай холбоотой асуудал дээр үүсээд байгаа юм. Тухайлбал, тухайн хуулиар борлуулсан энэ уул уурхайн бүтээгдэхүүний орлогыг богино хугацаанд улс орондоо татан төвлөрүүлэх энэ зохицуулалт бас бүрэн хангалттай хийгддэггүйн улмаас ганц “Эрдэнэс Тавантолгой” гэлтгүй хувийн хэвшлийн уул уурхайн компаниуд хүртэл борлуулсан уул уурхайнхаа баялгийн төлбөр мөнгийг оруулж ирэхгүй байгаад байгаа тохиолдлууд бас ажиглагддаг.

Тэгээд Монголбанкны зүгээс, Эдийн засгийн хөгжлийн яамны зүгээс, Уул уурхайн яамны зүгээс эдгээртэй холбоотой асуудлаар зохицуулалтуудыг хийж өнөөдрийг хүртэл ажиллаж байна. Цаашдаа энэ хуулийг шинэчлэх нь эхний

асуудал гэж бидний зүгээс үзэж байгаа юм.

Хоёрт, энэ мухар төмөр замуудыг холболт хийх асуудал дээр Засгийн газар санаачилгатай ажиллаж байна.

Өнгөрсөн жил Монгол Улсын Ерөнхий сайд Бүгд Найрамдах Хятад Ард Улсад айлчлах үеэр яригдсан. Энэ онд бас Монгол Улсын Ерөнхий сайдын Бүгд Найрамдах Хятад Ард Улсад хийх албан ёсны айлчлалын хүрээнд төмөр замуудын холболтын цэгүүдийг эцэслэн тохирох асуудлыг шийдвэрлэх зорилготой байгаа.

Мэдээж нэгдүгээрт нь Гашуунсухайтын холболтын терминалыг байгуулж холболт хийх асуудал эн тэргүүнд яригдаж байна.

Үүний араас Шивээхүрэн боомтын холболтын нүүрс ачиж буулгах терминалыг барих ажил төслийн түвшинд явагдаж байна.

Бидний төсөөлж байгаагаар эхний хагас жилдээ багтаад энэ бүтээн байгуулалтын ажил эрчимтэй эхэлнэ. Хэрвээ энэ ажил эхэлсэн тохиолдолд хоёроос гуравхан сарын дотор ашиглалтад орох боломжтой төсөл явж байна.

Ханги-Мандал боомтод өнөөдөртөө Бүгд Найрамдах Хятад Ард Улстай холболтын цэгээ эцэслэж тохироогүй байгаа.

Монголын талаас хувийн аж ахуйн нэгж төмөр замаа концессоор хийгээд хилийн цэгт хүргэсэн байдалтай явж байна.

Одоо Монголын төмөр зам дээр баруун босоо болон зүүн босоо төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг

концессыг нь зарлаад, гүйцэтгэгчийг нь сонгон шалгаруулах ажил процесс яг ид явагдаж байгаа гэдгийг бас танд хэлмээр байна.

Биржийн борлуулалтыг энэ онд 01 дүгээр сарын 01-нээс эхлүүлсэн. Биржийн хууль өөрөө албан ёсоор 07 сарын 01-нээс хэрэгжиж эхэлнэ.

Тэгээд эдгээр зохицуулалтыг өнөөдөр энэ бүрэн эрхт төлөөлөгчийг сунгахаар оруулж ирж байгаагийн бас нэг том учир шалтгаан. Энэ биржээр борлуулдаг нүүрсний борлуулалтын үйл ажиллагааг жигдрүүлэх, цаашлаад ер нь дан ганц нүүрс биш энэ уул уурхайн бүтээгдэхүүн, энэ төмрийн хүдэр, зэсийн баяжмал зэргийг бас энэ биржийн худалдаагаар худалдаалдаг болгох нь Засгийн газрын томоохон ажлуудын нэг гэж ойлгож болно.

Зүгээр энэ ондоо нийт борлуулагдаж байгаа нүүрсний 30-аас 40 хувийг Эрдэнэс Тавантолгойн хувьд биржээр борлуулна гэсэн төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Дараа жилээс эхлээд энэ хууль хэрэгжиж байгаатай холбоотойгоор бүхий л нүүрсний борлуулалтын үйл ажиллагаа биржээр худалдаалдаг болох тэр зарчим дээр очно гэдгийг хэлье.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсэгт нэмж хариулах хүн байна уу? 3 номер.

Ж.Ганбат: Б.Баттөмөр гишүүний асуултад би нэмэлтээр хариулья.

Яах вэ, “Эрдэнэс Тавантолгой” компани тэр онцгой дэглэм тогтоохоос өмнө худалдан авалт дээр нэг л болохгүй юм байсан. Тэр нь нууцад хамааруулж байгаад шууд гэрээ байгуулдаг. Бид үүнийг зогсоосон.

Ер нь нууцад хамааруулахгүй бүгдийг нь худалдан авалт юм нь ил тод нээлттэй явуулах ёстой гэдэг энэ зарчим дээр хатуу тогтсон.

Ер нь “Эрдэнэс Тавантолгой” компани Засгийн газраас ер нь цаашид энэ худалдан авалтыг ер нь бид нууцад хамааруулах байдлаар хийх нь нөгөө далд хэлбэр лүү юм шилжээд байна гэдэг байдал байна.

Нөгөө талдаа худалдан авалт дээр жишээ нь хөрс хуулалтын худалдан авалтын ажлын объём нь асар өндрөөр тавьдаг. Тэр нь бодитой бус. Түүндээ хүрдэггүй.

Ингээд нэг тоо тавьчихдаг. Нөгөөдхийг нь үзэхээр дуусаж өгдөггүй. Гэрээнийх нь хугацаа дуусаад байдаг.

Одоо бид сая 3 жилээр байгуулсан хөрс хуулалтын 2 багц гэрээний хугацаа дуусгавар болсныг нь сая зарлалаа шүү дээ.

Бид “Эрдэнэс Тавантолгой” компани дээр энэ тендерийг ном журмаар нь явуулдаг. Тендер гэдэг энэ асуудлыг авлига гэдэг үгнээс салгах, ном журмаар нь явуулах, нээлттэй энэ зарчмыг хатуу барьж байгаа.

Нөгөө талдаа тендер зарлаж байгаа ажлын объём юмнууд бодитой байх ёстой гэдэг байдлаар.

Ер нь нөгөө талдаа “Эрдэнэс Тавантолгой” компанийн худалдан авалт таны хэлж байгаа бол үнэхээр асар том. Бид улсын төсвийн хөрөнгө оруулалтаас давсан хэмжээний хөрөнгө оруулалтын хэмжээ зарлаж байсан ийм үеүд байгаа юм билээ шүү дээ.

Тэгээд нөгөө талдаа одоо өмнө нь зарлачихсан байсан, зарлаад шалгаруулчихсан худалдан авалтын зарим тоног төхөөрөмж, техникүүдийг бид цаашаа яаж тэрийг ашиглах вэ гэдэг нь бас асуудал үүсэж байна. Эдийн засгийн ямар нэгэн үр ашгийн тооцоогүйгээр зарлаад хаячихсан. Хувийн хэвшил тэр дээр нь ялчихсан. Нийлүүлээд эхэлчихсэн. Бид зогсоож болдоггүй. Зогсоо гэхээр нөгөө хувийн хэвшил дээр хүндрэл үүсдэг.

Ийм мэтийн асуудал байгаа учраас бид аливаа юмыг тооцоотой, эдийн засгийн үр ашигтай энэ компанид төрийн өмчийг үнэгүйдүүлэхгүй, үр ашиггүй байлгахгүйн төлөө л бүх юмыг нь ил тод, нээлттэй болгох ийм л зарчим барьж ажиллаж байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Хариулт хангалттай юу? Ц.Анандбазар гишүүн асуултаа асууя.

Ц.Анандбазар: Баярлалаа.

Эрдэнэс Тавантолгойн гэрээ сунгах асуудлыг дэмжиж байгаа.

Магадгүй Засгийн газрын өнгөрсөн хугацаанд хийсэн сайн гэж хэлж болох, магтаж болох цөөхөн тодотгож болох ийм ажлуудын нэг гэж харж байгаа.

“Эрдэнэс Тавантолгой” компани Монгол Улсын түрийвч болсон ийм уурхай эзэмшдэг компани. Энэ түрийвч баян байж Монгол Улс маань баян байна. Тэгээд түрийвч маань бас мөнгө төгрөгөөр элбэгшиж, валютын ханшийн сулралт явж, орлого нэмэгдэж байгаа нь маш сайн гэж үзэж байгаа.

Гэхдээ хоёр, гурван үүнийг дагаад асуулт байна.

Нэгдүгээрт, Ж.Ганбат дарга бол Төрийн нарийн бичгийн дарга энэ бүрэн эрхт төлөөлөгчийг давхар хавсарч байгаа нь ажил явахад их сайн харагдаж байна гэж үзэж байгаа.

Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга төрийн олон албыг зохицуулж уялдуулдаг. Тэр утгаараа Ж.Ганбат даргын үгэнд орохгүй төрийн байгууллага цөөхөн байх. Энэ нь ч бас ажилд явахад дөхөмтэй байгаа байх гэж бодож байгаа.

Тийм учраас цаашид Монгол Улсын түрийвчинд орж байгаа энэ их баялгийг зөв захиран зарцуулах, хийх ажлаа яаж хийх гэж байна вэ гэдгийг тодруулах гэсэн юм.

Мэдээж орлого нэмэгдээд байна. Тавантолгой компани төсвийн захиран зарцуулалт хийдэг ийм субъект байж таарахгүй. Энэ орсон орлогыг ажлын байр бий болгох. 2022 онд Их Хурлын гишүүдийн хийсэн хөрөнгө оруулалтыг тэглэсэн. Хөдөө орон нутаг, хөдөө аж ахуйд чиглэсэн олон хөрөнгө оруулалт царцсан байгаа.

Энэ тал дээр мэдээж хэрэг Сангийн яамны төлөвлөлт дээр суудаг Төрийн нарийн бичгийн дарга учраас энэ орсон орлогыг дахин эдийн засгийн эргэлтэд оруулахад онцгой анхаарах хэрэгтэй байна.

Өөрөөр хэлбэл хэрвээ шаардлагатай гэвэл төсвийн тодотгол дахиж хийх хэмжээний асуудал яригдах болох нь гэж би харж байгаа.

Тийм учраас та энэ тал дээр дараагийн удаа орж ирэхдээ их тодорхой саналтай, Их Хурлын гишүүд, тойргууд, ялангуяа малын гаралтай түүхий эдийг

байгалийн баялгаас аваад нөхөн төлждөг баялгийг эргэлтэд оруулахад ямар төсөв, төлөвлөгөө хийж байна вэ гэдэг тодорхой саналыг Засгийн газрын зүгээс оруулж ирвэл бид их талархахаар байна.

Орлого нэмэгдлээ гээд хаана үрэгдэж зарагдаж байгаа нь мэдэгдэхгүй алга болох юм бол энэ ард түмэнд хүртээлгүй болно.

Дээр нь бүрэн эрхт маань хугацаа сунгаж байгаа юм байна. Тавантолгой дээр олон зуун мянган ажлын байр гарч байгаа. Тэр олон зуун мянган ажлын байрыг хадгалж үлдэх тал дээр онцгой анхаарах хэрэгтэй.

Ер нь уул уурхайн хамгийн том зүйл бол уул уурхайг дагаж байгаа бизнесийг дэмжих асуудал байдаг. Тэгээд зарим тал дээр хараад байхад бизнесийг буруутгах ийм явц ажиглагдаад байгаа. Сүүлийн үед. Хэвлэл мэдээлэл, сошиал, зарим засгийн эрх мэдэлтнүүдийн хэмжээнд ч гэсэн тэр. Үүнийг огт гаргаж болохгүй гэдгийг бүрэн эрхтэд захимаар байна.

Ялангуяа хувиараа эрхлэх аж ахуй аж ахуй, хувиараа бизнес эрхэлж байгаа хүмүүсийг боломжит бүх хувилбараар дэмжиж ажиллах хэрэгтэй. Энэ ажлын байр чинь л эргээд эдийн засгийн өсөлт шүү дээ.

Дээр нь ард түмний хүсэн хүлээж байгаа зүйл байгаа. Энэ бол Тавантолгойн ногдол ашгийг хэзээ хуваарилах вэ гэдэг асуудал.

Ногдол ашиг хуваарилах асуудлыг энэ сардаа багтаж тодорхой болгож ард түмний хүсэн хүлээж байгаа тэр хүлээлтийг тодорхой болгомоор байна.

Болж өгвөл нэлээн шахуу байдлаар энэ эдийн засаг, үнэ хөлс, инфляцын түвшинг тэгшитгэх ийм орлого болох.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Ц.Анандбазар гишүүн үг хэлж, саналаа хэлж байгаа юм байна. 1 минут нэмж өгье.

Ц.Анандбазар: Энэ ноогдол ашиг хуваарилах тал дээр бас та ямар санаа оноотой байна вэ гэдгээ хэлэх хэрэгтэй байна.

Энэ дотор бас оффтейк гэрээн дээр газрын тосны хоолой барих нэг гэрээ байна. Үүний нэг вагонметрийн хөлс хүч тодорхой байгаа юу? Энэ тендерийг хаана явуулсан бэ?

Үүнийг хийх гэрээ ямар хэмжээнд шийдэгдэж, санхүүжүүлсэн бэ?

Газрын тосны үйлдвэр уг нь Д.Амарбаясгалан дарга байсан бол асуух гэж бодож байлаа.

Дээр нь түрүүнд их чухал асуудал хөндсөн. Б.Баттөмөр гишүүн. Мухар төмөр замыг ашиглалтад оруулж, төмөр замын логистикийн төвөө яаралтай оруулах хэрэгтэй.

Тэгэх юм бол экспорт их сайн нэмэгдэнэ.

Тэгэхээр та төмөр замын тэр мухарт байгаа хэсэг Хятадын тал. Дээр нь Тавантолгойгоос ачиж байгаа логистикийн төвийг маш хурдан оруулах хэрэгтэй. Энэ таны цаашдын ажилд их чухал болно гэж бодож байна.

Тэгээд Тавантолгойн хамгийн том хийсэн ажил тэр биржээр худалдаж байгаа асуудал гэж бодож байгаа.

Биржээр худалддаг худалдан авалт дээрээ зөвхөн.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Асуултад хариулья. Ажлын хэсгийн 3 номерыг нээе.

Ж.Ганбат: Ц.Анандбазар гишүүний асуултад хариулья.

“Эрдэнэс Тавантолгой” компани дээр 4.9 тэрбум ам.долларын төсөвт өртөгтэй нийт 11 төсөл яг хэрэгжиж байгаа.

Энэ 11 төслөөс үндсэн яг уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хүрээнд 2 төсөл байна.

Энэ бол уурхайн тоног төхөөрөмж, ил уурхайн конверын систем гээд. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг бий болгох төслүүд гэдэг дээр нүүрс баяжуулах үйлдвэр, Загийн усны төсөл, газрын тос дамжуулах төсөл, Тавантолгойн дулааны станц гээд.

Тэгээд төмөр замын гээд нийтдээ 5 гэрээ буюу Гашуунсухайт төмөр зам, Зүүнбаян төмөр замтай, Богд хаан төмөр зам гэж. Энэ нийтдээ 11 төсөл хэрэгжиж байгаа.

Энэ төслөөс 4.9 тэрбум төсөвт өртөгтэйгөөс 1.5 тэрбум ам.долларыг нь санхүүжүүлчихсэн явж байгаа.

Богд хаан төмөр замыг зогсоочихсон байгаа.

Газрын тос дамжуулах хоолой дээр 388.1 сая долларын төсөвт өртөгтэй. Үүнээс 19.4 сая долларыг нь санхүүжүүлчихсэн. Гэрээнийх нь хугацаа нь 2022 оны 7 сараас 2024 оны 12 сард дуусах гэдэг ийм байдлаар ажил нь явж байгаа.

Газрын тос дамжуулах хоолойг “Эрдэнэс Тавантолгой” компани зөвхөн санхүүжүүлэх байдлаар явж байгаа. Ийм байдлаар явж байгаа. Үүнийг тусдаа төслийн нэгж хяналт тавиад явж байгаа. Ийм байгаа.

Ногдол ашгийн хувьд өнгөрсөн 2022 онд “Эрдэнэс Тавантолгой” компани 1.3 их наяд төгрөгийн ашигтай ажилласан. Энэ компанийн 18.4 хувийг нь 2012 оны 04 сарын 11-нээс өмнө төрсөн 2.5 сая иргэд эзэмшиж байгаа.

Энэ иргэддээ бид ногдол ашиг тараах эсэх асуудлаа ТУЗ-даа танилцуулна. Аудитын тайлангаа бид ТУЗ-даа ирэх долоо хоногт танилцуулаад хувьцаа эзэмшигчдийн хурал 04 сарын 28-нд зарлагдсан байгаа.

Гэхдээ яг бодит байдал дээр бид “Эрдэнэс Тавантолгой” компани энэ баяжуулах, угаах үйлдвэрийг л бид яаралтай ашиглалтад оруулах. Энэ төмөр замуудын холболтыг яаралтай хийж байж бид илүү их ашиг олно.

Гэхдээ бид ногдол ашиг 2019 оны ашгийг л түүхэндээ 2020 онд нэг тараасан. Нэг иргэнд 93 билүү, 96 мянган төгрөг тараагдсан юм байна лээ. Яг тэр зарчмаар одоо хуваах юм бол тэр 2018 оны 4 хувь эзэмшиж байгаа 2.5 сая иргэнд 100, 100 жоохон гаруй мянган төгрөг л оногдох юм билээ.

Тэгэхээр бид ингэж хуваарилах уу, эсвэл энэ угаах үйлдвэрээ дуусгаад ашигтай төслүүд дээрээ явуулаад илүү үр ашгаа нэмж байж дараа нь ногдол ашгийн асуудлыг авч үзэх үү гэдэг асуудлыг л ТУЗ хувьцаа эзэмшигчдэдээ танилцуулж байж шийдлээ гаргах нь зүйтэй юм гэдэг ийм байр суурийг баримталж байгаа.

Тэгээд эцсийн шийдвэрийг мэдээж хувьцаа эзэмшигчдийн хурал гаргана.

Ц.Цэрэнпунцаг: Ж.Батжаргал гишүүн асуултаа асууя.

Ж.Батжаргал: Тийм. “Эрдэнэс Тавантолгой” дээр онцгой дэглэм тогтоогоод, бүрэн эрхт төлөөлөгч томилоод нөхцөл байдал саяын орж ирж байгаа тайлан мэдээллээр нэлээн гайгүй нааштай болсон юм.

Тэгээд энд хоёр, гурван зүйл нөлөөлсөн юм билээ.

Нэгдүгээрт, ерөөсөө Засгийн газар энэ салбарт бий болчихсон нөхцөл байдлыг зөв болгох чиглэлээр баримталсан бодлого их том нөлөө өгсөн.

Дээр нь Уул уурхайн биржийн тухай хууль батлагдсан. Үүнийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд тодорхой туршилтын борлуулалтын асуудлууд хийгдсэн нь энэ салбарт бас их том нөлөө үзүүлсэн юм билээ.

Тийм учраас нэгэнт бий болсон энэ нааштай үр дүн, тогтворжилтыг хадгалахын тулд БЭТ-ийг нэг удаа сунгах бололцоо байна. Үүнийг дэмжих ёстой юм байна гэж ингэж харж байгаа.

Гэхдээ энэ хугацаанд одоо тэр компанийнхаа хуулийн дагуу явдаг бэлтгэл зохион байгуулалтыг нь хангах ёстой. БЭТ-ээр цаашаа дахиад хугацаа сунгаад үргэлжилдэг юм гэж байхгүй.

Тэгэхээр сая Ж.Ганбат очоод тэнд нэлээн гайгүй үр дүнгүүдийг бий болголоо.

Тэгэхээр зэрэг ерөөсөө энд харагдаад байгаа зүйл юу вэ гэхээр зэрэг

эрх зүйн орчныг зөв бүрдүүлэх тухай асуудал байгаад байгаа юм.

Тийм учраас би Эдийн засгийн байнгын хороог анхааралдаа аваач ээ гэж хэлэх гээд байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоот компаниудын тухай хуулийг оруулж ирж маш яаралтай батлуулах ёстой.

Үүн дээр би Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга тэнд “БЭТ” хийж байгаагийн хувьд эрх зүйн хувьд нь ямар зохицуулалт шинэчлэлтүүдийг хийх ёстой вэ.

Компанийн дотоод дүрэм журамд ер нь ямархуу зохицуулалт шинэчлэлтүүд хийж байж хүнээс үл хамаарсан тэр ёстой нөгөө хууль засагладаг үйл явц нь яаж хэрэгжих энэ одоогийн нөхцөл байдал арилах бололцоо байна гэдэг энэ тайлан мэдээллийн санал, дүгнэлтүүдийг нь ахиутай авч энд эрх зүйн орчны шинэчлэлийн хүрээнд тодорхой оруулж ирэх нь би зүйтэй гэж ингэж ойлгоод байна.

Гурав дахь хэлмээр байгаа зүйл. Ер нь тэгээд ний нуугүй үнэнийг хэлэхэд энэ дур зорго гэдэг юмыг эрх зүйн хувьд нь зөв зохицуулахгүй болохоо байчхаад байгаа юм.

Хүн засагладаг биш, хууль засагладаг улс орон байя гэдгийг хаа хаанаа их ярьцгаагаад байгаа. Ашигтай гарсан юм бол зүгээр хэн нэгэн ашиг хуваах хуваахгүйн тухай ярьдаггүй л байхгүй юу. Тэр хуулиараа л зохицуулагдаад л явдаг байх ёстой.

Том бүтээн байгуулалт хийх гэж байгаа бол харин тэр улсуудад хуваарилах гээд байгаа ашгийг нь буцаагаад тэр хувьцааных нь юун дээр

нэмж тооцох хэлбэрээр өсгөж болно шүү дээ. Тэр үнэт цаасыг. Нэг хүнд 1072 биш, тэр тараах гээд байгаа 100 мянган төгрөгөөр нь гэдэг юм уу, нэмээд хувьцааг нь өсгөж болно шүү дээ. Хүн болгон дээр. Тэр мөнгийг нь татаж ажиглах шаардлага байна л гэж байгаа бол.

Тэгээд ийм зохицуулалтуудыг нь маш яаралтай хийж өгөхгүй бол энэ олон нийтийн засаглал, хяналт, тэгээд үр өгөөжийн тухай асуудал ярихад эргэлзээ үүсгээд болж өгөхгүй байгаа юм.

Тийм учраас үүнийг би Эдийн засгийн байнгын хороог онцгой анхааралдаа авч ажиллаач гэдгийг хэлье.

Тэгээд “БЭТ” түүний багийнханд нэгдүгээрт гайгүй ажлын үр дүнг нь үнэлж талархал илэрхийлээд, энэ ажлаа улам сайн чамбайруулаад энэ 6 сарын хугацаанд ажиллаад.

Тэгээд үлдэх юм чинь бол тэр эрх зүйн орчныг бүрдүүлээд. Таныг явахад хэн ч очсон л яг энэ шиг чинь ажиллаж чадах л тийм л нөхцөл байдлыг л бий болгосон байх ёстой бид хэд.

Ц.Цэрэнпунцаг: Ж.Батжаргал гишүүн үг хэлчихлээ. Тийм ээ.

С.Ганбаатар гишүүн асуултаа асууя.

С.Ганбаатар: Энэ бүрэн эрхт төлөөлөгчийг сунгах ажлыг дэмжихгүй байна. Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороогоор орж ирэхэд би биржтэй холбоотой асуудал дээр байр сууриа илэрхийлж байсан. Надад хэлэх цаг олдоогүй байсан.

Нэгдүгээрт, онцгой дэглэмийг яагаад дэмжихгүй байна вэ гэвэл онцгой

дэглэм энэ Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хууль дотроо шаардлагатай шуурхай арга хэмжээ гэж байгаа юм шүү. Шуурхай гэдэг бол нэг жил байна гэж байхгүй шүү. Ийм дампуурсан юм гэж юу байдаг юм бэ. Шуурхай.

Хоёрдугаарт, 10 өдөр тутам явцыг нь олон нийтэд танилцуулна, түмэнд мэдээлнэ гэж байгаа юм. Нөхцөл байдал арилаагүй бол хугацааг сунгана гэсэн ийм үг байна л даа.

Тэгэхээр хулгай арилаагүй гэсэн үг үү? Та нар тэр түрүүний нөхцөл байдлуудыг ярихад зүгээр гурилдсан зүйлүүд л ярьж байна.

Би яах вэ анх Ж.Ганбат бүрэн эрхт төлөөлөгчийг томилж байхад төлөөлөн удирдах зөвлөлд байсан, тэр хулгай хийж байхад хамт байсан бүхнийг нь мэдэж байгаа гэж бодоод энэ хүн томилогдох нь аргагүй биз дээ гэж бодож байсан.

Тэгэхээр эхний асуулт. Энэ Бүгд Найрамдах Монгол Ард Улсын энэ тогтоол дотор байна л даа. 4 дүгээр зүйл дээр. Тусгай хяналт тогтоох гэж байгаа. Хянасан юм байна.

Өмнөх Б.Ганхуяг гэдэг хүнд л ганцхан тохоод хаях биш ээ. Өмнөх төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээс хэд нь байгаа вэ? Одоо. Яаж хариуцлага тооцсон. Тэд шийдвэр гаргасан. Тэд араас нь хэрэгжилтийг нь хянах ёстой. Тэд мангас бэлдсэн.

Нэг домог байдаг юм л даа. Ард түмний зовлон зүдгүүрээр эд хөрөнгөөр баяжиж байгаа мангасыг дарах гээд БЭТ гээд нэг том баатар явуулсан. Очоод мангасаа дарчхаад тэгээд гялалзсан эд баялаг харангуут л үс ургаад эхэлсэн гэсэн нэг домог байдаг юм л даа.

Түүн шиг ингэж сунгана гэж байхгүй. Очоод тэр мангасаа дараад л баатарлаг гавьяагаа байгуулаад л дараагийн ажлаа хийх ёстой. Миний нэгдүгээр асуулт тэр ТУЗ-д байсан хүмүүст хариуцлага байгаа юу?

Хоёрдугаар асуулт. Монгол Улсын Хөгжлийн банкны ТУЗ-ийн дарга Ж.Ганбат, “Эрдэнэс Тавантолгой” компанийн ТУЗ-ийн гишүүн Ж.Ганбат, Эрдэнэс Тавантолгой гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Ж.Ганбат, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат.

Энд ер нь чекин баланс гэж байна уу? Та нарт ер нь өөр БЭТ тавьчих хүн байдаггүй юм уу? Зүгээр л энэ хувь хүн яриагүй шүү дээ. Би.

Түрүүн нэг ийм ухаантай мундаг хүн Та нар томилох гээд байгаа юм биш шүү дээ. Хэн ч очсон сайн ажил хийх системийг бий болгоё л гэж байгаа юм.

Надад Үйлдвэрчнээс 3 гомдол ирсэн байна. Үйлдвэрчний гишүүдээс.

“Моннис Майнинг” гэдэг компанитай холбоотой гомдлыг би эхнээс нь ярья. Надад цаг гарах нь уу. Гурвууланг нь яримаар байна.

Монгол Улсын Хөгжлийн банкны ТУЗ-ийн дарга Ж.Ганбат аа, Монгол Улсын Хөгжлийн банкнаас 107 тэрбум төгрөгийг хугацаа хэтэрсэн өртэй энэ “Моннис майнинг” гэдэг компани өнөөдөр танай энэ Тавантолгойгоос “ЭТТ” ХК 202302001 дугаартай 1.2 их наядын тендер дээр ялалт байгуулсан байна. 2 дугаар багцад нь.

Энэ шударга үнэн үү? Энэ дараагийн нүүрсний хулгай явчихсан байна шүү дээ.

Энэ 7 сонин дээр энэ гарсан байна. Нөгөө ард түмэнд илтгэх ёстой юм чинь 7 сонин дээр. Тэгээд энэ дээр “Эрдэнэс Тавантолгой” компани улсад өртэй, улсад хугацаа хэтэрсэн өртэй энэ хүн улсаас ийм хууль бус тендер авч болох уу?

Асууя даа, Ж.Ганбат аа, би. Тендерт оролцогч нь харилцагч банкнаасаа хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн өр төлбөргүй байна гэсэн заалт байна.

Тэгээд энэ чинь улс даяар “Моннис майнинг” 126 тэрбум төгрөгийн найдваргүй зээлийн ангилалтай байгаа нь ил тод болсон гээд материал нь.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Хариулах уу? Ажлын хэсэг 3 номер хариулья.

Ж.Ганбат: С.Ганбаатар гишүүний асуултад хариулья.

“Эрдэнэс Тавантолгой” компанийн ТУЗ-ийн гишүүнээр намайг Засгийн газраас 2022 оны өнгөрсөн оны 4 сард томилогдсон. Би тэрнээс өмнө ТУЗ-ийн гишүүн байгаагүй. Үүнийг хүмүүс байсан мэтээр өмнө нь яриад байгаа. Би 2022 оны 4 сард ТУЗ-ийн гишүүнээр болсон.

Одоо байгаа ТУЗ-ийн гишүүд тухайн үед байсан ТУЗ-ийн гишүүд нь байхгүй юм байна лээ. Чөлөөлөгдчихсөн. Шинэ ТУЗ-тэй явж байгаа.

Би энэ дээр ингэж байгаа. Дараагийн юм нь. Би Хөгжлийн банк, Сангийн яамны харьяанд Хөгжлийн банк байдаг. Албан тушаалаараа надаас өмнө байсан Төрийн нарийн бичгийн дарга Хөгжлийн банкны ТУЗ-ийн дарга хийж байсан.

Би Хөгжлийн банкн дээр ТУЗ дээр очоод тэр Хөгжлийн банкны чанаргүй зээлийг барагдуулахад тодорхой ажлуудыг зохион байгуулж хийсэн.

Би тэр Хөгжлийн банкны захирал шиг ил гарч юм яриагүй. Энэ дээр бүх юмыг нь зохион байгуулаад тэр Хөгжлийн банкиг өнөөдөр хэвийн үйл ажиллагаанд оруулахын төлөө бид тусгай хөтөлбөр гаргана, төлөвлөгөө гаргана. Тэрний биелэлтийг нь шахаад ажиллаж байгаа.

Би өнөөдрийг хүртэл Сангийн яаманд ажиллаад ингэсэн. Үүнийг маань бодвол хаяж байгаа учраас “Эрдэнэс Тавантолгой” компани дээр цэгцэл гэдэг ийм л юм байдлаар тавьсан. Энэ дагуугаа л бид ажиллаж байгаа.

Таны хэлээд байгаа тэр “Моннис” гэж компанитай холбоотой асуудлыг бид сонгон шалгаруулалтыг нь зарласан. Одоогийн энэ тендерийн үнэлгээг нь гаргасан манай худалдан авахын энэ Н.Цэрэнсамбуу дарга нэмэлтээр тайлбар хэлнэ.

Бид энэ тендерийг та 1.2 их наяд гээд байна. Энэ 553 тэрбум төгрөгийн өртөгтэй тендер. Хоёр багц. Хоёулаа нийлээд нэг аравны хэд гэж байгаа юм.

2 дугаар багц дээр “Моннис” гэж компани ингээд шалгарсан гэсэн.

Энэ бол Хөгжлийн банкн дээр өртэй гэдэг асуудал яриад байна. Тэгэхдээ Хөгжлийн банкныхаа өрийг төлөөд явж байгаа юм билээ. Чанаргүй, найдваргүй гэдэгт ороогүй.

Нөгөө талдаа бид яг тендерт шалгаруулахдаа хуулиараа татвар,

нийгмийн даатгалын өргүй гэдэг байдлаар нь үзээд л шалгаруулсан. Яг л ном журмаар нь.

Ер нь нөгөө талдаа харилцагч банкн дээрээ хугацаа хэтэрсэн чанаргүй зээлтэйг тэр бол өөр асуудал гэдэг байдлаар үүнийг ил тод нээлттэй явуулсан. Үүнийг бид хаана ч хэлнэ. Бид үүнийгээ бүх газар нь хэлээд энэ асуудлыг нь хянаад бид нээлттэй ил тодын нэг нь яриад л явж байгаа.

Ер нь нөгөө талдаа бид энэ компани дээр. Түрүүн би хэлсэн. Ер нь Монгол Улсад тендер гэх дээр энэ авлига гэдэг үгтэй холбогдсон асуудлаас бид энэ асуудлыг “Эрдэнэс Тавантолгой” компани дээр бид ил тод нээлттэй болгож үүнээс салгана. Үүний төлөө л ажиллаж байгаа.

Түүнээс биш бид Хөгжлийн банкнд өртэй “Моннис”-ыг шалгаруулсан гэдэг асуудал байхгүй.

Бид 2 багц шалгаруулсан хугацаа нь дууссан. Бид өртгийг нь яг бодитой тооцсон. Өртгийг нь бид бууруулж зарласан шүү дээ. Өмнө нь зарлаж байсан явж байсан хүн нь бас хөөс үүсгэчихсэн байсан. Энэ дээр янз бүрийн тэр хууль хяналтын шалгаж байгаа асуудал байгаа юм билээ.

Бид үүнийг нь нэг хөрс хуулалтын энэ багц дээрээсээ бид тодорхой хэмжээний хэмнэлт гаргах байдлаар зарласан. Тэгээд яг тендертэй холбоотой мэдээллийг нь манай худалдан авахын дарга тэр комисс ахалсан хүн яг тэрийгээ мэдээлэл өгөх нь зөв байх.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн 1 номероос нэмж хариульа.

Ажлын хэсгийн 2 номерыг нээчихье тэгвэл. 2 номер нээлттэй байна. Тийм.

Н.Цэрэнсамбуу: “Эрдэнэ Тавантолгой” компанийн Худалдан авах ажиллагааны газрын дарга Н.Цэрэнсамбуу. С.Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Түрүүн асуултад нэр дурдагдсан “ЭТТ” ХК 202302001 кодтой хөрс хуулалтын ажил багц 2 цонхын баруун уурхайн хөрс хуулалт, олборлолтын ажил. Төсөвт өртөг 647 тэрбум 472 сая 63 мянга 310 төгрөг байсан.

Бид энэ дээр тендерийн баримт бичиг дээр нэг метр куб уулын цулын ажлыг 11 мянга 982 төгрөгөөс хэтрүүлэхгүйгээр санал ирүүл гэсэн ийм нэмэлт шаардлагыг тусгаснаараа тендэрт оролцогч нар өмнөх гэрээт олборлогч нар 12 мянга 913 мянган төгрөгөөр хийгддэг гэрээтэй. Гэрээ нь дууссаныг бид мянга гаруй төгрөгөөр бууруулаад зарласан.

Нэр дурдагдаад байгаа “Моннис Майнинг” компани бол 575 тэрбум 183 сая 942 мянга 500.

Энэ "Овоот Толгой Ресурсес" гээд компани 594 тэрбум 690 сая 184 мянга 117 төгрөгөөр гүйцэтгэхээр санал ирүүлсэн.

Энэ хоёрын ирүүлсэн саналын зөрүү бараг одоо ингээд 20 орчим тэрбум, 19 орчим тэрбум төгрөгийн зөрүү байгаа.

Мэдээж тендер зарлана гэдэг маань холбогдох тендерийн баримт бичиг. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль. Энэ хуулийг дагаж гарсан дүрэм, журмуудаар зохицуулагддаг.

Эрх бүхий этгээд гэж юуг хэлэх вэ гэхээр хуулийн 14 дүгээр зүйл дээр тусгайлан зохицуулсан байдаг. Энэ дээр хуулийн 14.1.2-т Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан хуулийн дагуу татвар, хураамжаа төлсөн байх ёстой. Төлбөрийн чадваргүй болсон нь татан буугдаж байгаа, дампуурлаас зайлсхийх зорилгоор зээлдүүлэгчтэй тохиролцсон бизнесийн үйл ажиллагаа нь зогсоосон, эсхүл энэ хуулийн үүсгэн байгуулагдсан хуулийн дагуу дээр дурдсантай адилхан нөхцөл байдал үүссэн гэх мэтчилэн хэд хэдэн 7 зохицуулалт байдаг.

Үүнийг нь юугаар нотлох вэ гэхээр тухайлах юм бол санхүүгийн чадварыг юугаар нотлох вэ гэхээр санхүүгийн чадварыг дараах бичиг баримтаар нотолно.

Харилцагч банкны мэдэгдэл, тендэрт оролцогчийн баталгаажуулсан санхүүгийн тайлан, шаардлагатай бол аудитын дүгнэлтийн хамтдаа гэсэн ийм зохицуулалт байдаг.

Энэ “Моннис майнинг” компани бол нэр бүхий харилцагч 4 банкнаасаа янз бүрийн хугацаа хэтэрсэн өр төлбөргүй гэсэн байдлаар тендэртээ орсон.

Ер нь Их Хурлын чуулган дээр, Байнгын хорооны хурал дээр нэг тендерийн ийм нарийвчилсан юм яриад байх нь бас хэр зохимжтой вэ гэдгийг бас доор бүрнээ бодох нь зүйтэй байх.

Зүгээр нарийвчлаад үзэх юм бол яг энэ 4 банкнаасаа өргүй...

Ц.Цэрэнпунцаг: Та зогсож бай даа. Хөөе. Н.Цэрэнсамбуу.

Та Их Хурлын гишүүд энд юу ярихыг заагаад байхгүй шүү. Ойлгосон уу? Наадах ярьж байгаа өнгө аясаа эвтэйхэн бодож яриарай.

Н.Цэрэнсамбуу: Энэ гомдол гараад хянагдаж байгаа болохоор нарийн ярих боломжгүй л гэсэн санаагаар.

Ингээд яг тендерийн баримт бичгийн бүх шаардлагуудаа хангасан.

Гэхдээ мэдэгдэл дээр 27.1, 27.2.1, 2.2-т заасны дагуу буюу зарим гэрээг хэрэгжүүлэхэд сөрөг нөлөө үзүүлэхгүй гэж үзсэн зүйлийг үнэлгээний хороонд бүгдийг нь залруулга хийх байдлаар бүх оролцогчийг шаардлагад нийцсэн байна гээд.

Тэгээд хуульд заасан 27.1-д заасны дагуу хамгийн бага шаардлагад нийцсэн дотроос хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг шалгаруулна гэсэн заалтаараа “Моннис майнинг” компанийг шалгаруулсан байгаа.

Тэгээд Сангийн яаман дээр гомдол гараад хянагдаж байгаа учраас бүр нарийн дэлгэрэнгүйг нь энд ярих боломжгүй байна гэж хэлье.

Ц.Цэрэнпунцаг: Нэмэлт асуултаа асууя.

Нэг юм өмнө нь хэлчихье. Сая ч би хэлсэн. Тэвчсэнгүй дундуур нь хэллээ.

Бид энд Их Хурал дээр тойрог дээр хийх ажлууд дээрээ 500 сая, тэрбумыг яриад байж байдаг юм шүү дээ.

Та нар хагас их наядаар гэрээ хийхээд тэгээд тэр гэрээнийх нь талаар энэ гишүүд асуухаар зэрэг энэ зохистой, зохисгүйг нь тэнд заагаад байж байдаг. Ингэж болох юм уу.

Энэ мэдээллийг шаардлагатай бол гишүүддээ өгнө шүү. Тэгээд энд зааварчилгаа өгөөд сууж байдаг ийм том хүмүүс энд байж болохгүй шүү.

С.Ганбаатар гишүүн нэмэлт асуултаа асууя.

С.Ганбаатар: Ингээд яах вэ, 1.2 их наядын тухай тендер битгий ярь л гэж байна. Хөөрхий, энэ чинь улсын төсвийн 5 хувьтай тэнцүү шүү дээ. 1.2 их наядын тендер зарлаад ирэхээр л биед нь үс ургаад эхэлдэг юм даа. Мангас болж байгаа нь энэ шүү дээ. Гишүүд ч жижигхэн харагдаад л эхэлнэ дээ.

Тэгээд саяын ярьсан юм хамгийн хямдхан хамгийн гайгүй л гэж яриад байна. Хамгийн чадваргүй, хамгийн хямдыг нь хууль зөрчин байж шалгаруулаад хоёр сарын дараа Та нар үнэ нэмэх хүсэлтийг нь аваад, үнийг нь төсөвт нь тулгал нь нэмж өгөөд үргэлжилдэг. Бүгдээрээ мэднэ шүү дээ.

Тэр тендерийн гэрээн дотор нь үнэ нэмэгдэх нөхцөлтэй гэрээ байгаа шүү дээ. Та нарын луйврыг бүгдийг нь мэднэ шүү дээ.

Тэгээд өнөөдөр 4 давхар дээл өмсчихсөн байна. Энэ дээр.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Т.Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Т.Энхтүвшин: Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч томилсон. Томилоод 6 сарын хугацаа өнгөрч байна.

Энэ хугацаанд үр дүнд хүрсэн байж байгаа. Ялангуяа юу гэдэг юм нүүрсийг хил үнээр зардаг болсон. Нүүрсний тодорхой хэсгийг биржээр

зардаг болсон. Ил тод байдлыг нэлээн сайн хангаж ажилласан. Мөн удирдах ажилтны тоог цөөрүүлсэн. Хөрс хуулалтын мэдэхгүй үнийг ч тэгсэн бууруулсан гээд маш сайн үр дүнгүүд гарсан.

Тийм учраас үүнийг цаашдаа сунгаад явах нь зөв өө гэдэг дээр байр сууриа илэрхийлж байна. Яагаад ингэж хэлж байна гэхээр бид бас Үйлдвэржилтийн байнгын хороон дээр 10 гаруй хоногийн өмнө бас Эрдэнэс Тавантолгойн бүрэн эрхт төлөөлөгч томилогдсоноос хойших хугацааны тайланг сонссон.

Тэгээд энэ дээр маш сайн ажиллаж байна. Цаашдаа сунгаж болно, сунгах нь зүйтэй гэдэг чиглэлийг гаргаад явсан.

Ихэнх гишүүд маань нэг юман дээрээ бас анхаарал хандуулаад яриад байх шиг байна. Ялангуяа Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газарт эрх олгох тухай 1991 оны хуулийг хууль зөрчиж байна, хүчингүй болсон. Цаашид хэрэглэх бололцоо боломж муутай гэдэг ийм асуудал яриад явж байна.

1992 онд Үндсэн хууль батлагдахад Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хуулиас Монгол Улсын Үндсэн хуулийг бүрнээ дагаж мөрдөх шилжих тухай журмын тухай хууль гарсан байгаа.

Энэ журмын тухай хуулиар одоо 1991 оноос өмнө хуулиудыг өөрчлөх хугацааг өгсөн байгаа. Тэгээд өөрчлөгдөөд явж байгаа. Тэгээд энэ 6 хууль яг хүчин төгөлдөр мөрдөгдөөд явж байгаа юм байна.

Ялангуяа юу гэдэг юм хуулийн legalinfo дээр хүчин төгөлдөр мөрдөгдөж

байгаа 600 гаруй хууль дотор 1991 онд батлагдсан 6 хууль одоо хүртэл хүчин төгөлдөр явж байгааг хууль тогтоомжийн лавлагаанаас харахад байж байгаа юм.

Тийм учраас юу хэлэх гээд байна вэ гэхээр энэ бол хууль зөрчсөн асуудал биш. Энэ хуулийг өөрчлөх эсэх асуудал нь шинэчлэн найруулах асуудал нь Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал байгаа юм.

Тэгэхээр Улсын Их Хурал юу гэдэг юм энэ хуулиа шинэчилж найруулаагүй байгаа юм чинь энэ хууль одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа гэж Та бүхэн маань бас ойлгох хэрэгтэй байгаа юм.

Тэгээд цаашдаа би юу гэж бодож байна вэ гэхээр хийх ажил зөндөө байгаа байх. Ялангуяа бид нэмүү өртөг шингэсэн, ажлын байрыг нэмэгдүүлсэн, татварын бааз суурийг нэмэгдүүлсэн ийм үйлдвэрүүдийг л цаашдаа барья гэдэг ийм концепцыг л бид бариад явж байгаа шүү дээ.

Тийм учраас юу гэдэг юм тэр угаах үйлдвэрээ яаралтай ашиглалтад оруулах хэрэгтэй. Бид нэмүү өртөг шингээж байж л жоохон ашиг олно. Ажлын байрыг нэмэгдүүлнэ.

Хоёр дахь асуудал бол одоо бид нарын жилийн жилд ярьдаг асуудал байгаад байгаа юм. Эрчим хүчний дутагдалд орлоо. Нүүрсээ эдийн засгийн эргэлтэд оруулж цахилгаан станц барья гэдэг ийм асуудал яригддаг.

Тийм учраас яаралтай та хэд маань байгаа хугацаандаа энэ Тавантолгойн станцыг бариулах, тендерийг зарлах энэ ажлыг бас эхлүүлэх, ажлыг яаравчлан бас хийх ёстой гэсэн ийм байр суурьтай байгаа.

Тэгээд ярих юм бол ер нь цаашдаа бид коксын үйлдвэр ч гэдэг юм уу, бусад төрлийн үйлдвэрүүдийг нэмэгдүүлэх, ашиг орлогоо сайжруулах энэ зүйл дээр л гол чиглэлээ барьж ажиллавал илүү их үр дүн гарна гэдэг дээр Та бүхэндээ санал байж байгаа.

Мөн Та бүхэндээ бас нэг зүйл хэлэхэд цаашдаа энэ урт хугацаанд гэрээ байгуулаад явчих, яг гангийн үйлдвэртэй, дулааны станцтай, цаана их газар үйл ажиллагаа явуулж байгаа том компаниудад яг хэрэглэгчид нь энэ нүүрсийг худалдаж борлуулах.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Д.Батлут гишүүн. Сая Т.Энхтүвшин гишүүн ерөнхийдөө санал хэлчихлээ. Тийм ээ.

Ингээд Д.Батлут гишүүн асуултаа асууя.

Та бүхэн тэгээд энэ хэлж байгаа саналуудыг бас сайн анхааралтай сонсоорой.

Дараа нь бид энэ ажлыг дүгнээд хэлэлцэх, бас уулзах цаг гарах байх. Тийм ээ. Энэ дээр сайхан тодорхой, энэ гишүүдийн тавьж байгаа саналуудыг нь тодорхой хариулж байвал зүгээр байгаа шүү. Д.Батлут гишүүн асуултаа асуу.

Д.Батлут: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Монгол Улсын Засгийн газраас “Эрдэнэс Тавантолгой” компанийн үйл ажиллагаатай холбоотой тодорхой арга хэмжээ авч БЭТ томилж, мөн Их Хурлаас Уул уурхайн биржийн тухай хуулийг батлан гаргаж, батлан батлагдсан даруйд нь хэрэгжих нөхцөл байдлыг бүрдүүлснээрээ бас өнөөдрийн энэхүү

Тавантолгой компанийн ашигт үйл ажиллагаа нэмэгдсэн.

Мөн гаднаас оруулж ирэх валютын нөөц маань нэмэгдсэн. Түүнчлэн Монгол Улсын байгаа валютын ханшийн асуудал харьцангуй бууж эхэлж байгаа ийм нааштай үр дүнгүүд гарч байгаа гэж харж байгаа.

Тэгэхээр Засгийн газраас оруулж ирж байгаа БЭТ-ийн хугацааг сунгах асуудлыг дэмжиж байгаа. Цаашлаад энэ үйл ажиллагааг тогтворжуулах тал дээр онцгой анхаарч, илүү үр өгөөжөө өгөх тэр боломжуудыг бүрдүүлэх тал дээр ажиллах зайлшгүй шаардлага байна гэж харж байгаа.

Тэгэхээр олон гишүүд ярьж байгаа. Ийм байгаа ч гэсэн хуульд нийцүүлэх шаардлага байгаа шүү гэж.

Тэгэхээр Бүгд Найрамдах Монгол Ард Улсын тэр хуулийг барьж байгаа. Цаашлаад бид яах ёстой, тэр хуулийг гэдэг дээр онцгой анхаарч дараа дараагийн шатанд Засгийн газар маань арга хэмжээ авах байх гэж харж байна.

Хоёр, гурван асуулт байна.

Таны мэдээлэл дотор төлбөрийг нүүрсээр төлдөг гэрээний тоог бууруулав гээд тэр Тавантолгой, Гашуунсухайт төмөр зам, Богд хаан төмөр зам, нүүрс баяжуулах үйлдвэр гээд улс орны хэмжээнд хэрэгжиж байгаа томоохон төслүүдтэй холбоотой асуудлуудыг гаргаад ирчихсэн байгаа юм.

Тэгвэл танай компанийн дотоод ажилд ажил үүрэг гүйцэтгээд. Тухайлах юм бол хөрс хуулалт хийдэг ч юм уу, элдэв төрлийн бараа, бүтээгдэхүүн нийлүүлдэг ч юм уу, ажил, үйлчилгээ гүйцэтгээд түүнийхээ төлбөрийг

нүүрсээр хийсэн ийм гэрээнүүд байна уу?
Байгаа бол хичнээн гэрээ байгаа вэ?

Тэр гэрээнүүдийн үнийн дүн, тонныг нь хэдэн доллароор тооцож гэрээ байгуулсан бэ гэдэг дээр нь хариулт өгөөч ээ.

Яагаад би ийм мэдээллийг яриад байгаа вэ гэхээр ер нь ийм мэдээлэл байгаа. Хөрс хуулалтын ажлууд хийчихсэн. Тэгээд хөрс хуулалтын ажил хийхдээ тэр гэрээгээ байгуулахдаа хямд өртгөөр бартер хэлбэрээр гэрээ байгуулсан гээд.

Тэгэхээр үүнээс бид ямар ашиг, алдагдал хүлээж байгаа юм гэдгийг анхаарч үзэх хэрэгтэй байна гэж харж байна.

Хоёрдугаарт нь, Уул уурхайн биржийн тухай хууль батлагдаад явж байгаа нь сайн хэрэг. Түүний үр дүнгүүд гарч байна.

Тэгэхдээ манай та хэлсэнчлэн нүүрсээ сорчилж гаргахгүй байгаа гэж байгаа. Одоогийн байдлаар нүүрсээ 20 гаруй төрлөөр ангилж ялгаж байх шиг байна.

Тэгэхээр манай лабораториуд энэ 20 гаруй төрлийг ангилсан нүүрсийг шинжилж судалж, дүгнэлт гаргах лабораториуд маань хүчин чадлын хувьд хэр байгаа юм бэ? Хүрэлцэж байгаа юу?

Дээрээс нь техник, технологийн хувьд нийцэж байгаа юу? Нэг ёсондоо олон улсад хүлээн зөвшөөрөгдөх боломж бололцоо нь байгаа юу гэдэг дээр нь хариулт өгөөч ээ. Мэдээж ингэж байж цаашаа явна гэж харж байна.

Гуравдугаарт нь, би энэ ногдол ашигтай холбоотой асуудлыг яриад л

байгаа. 3, 4 жил ногдол ашгийн асуудал яригдсан.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Эхлээд хариулчихъя. Ажлын хэсгээс хариулчихъя. Тэгээд дараа нь нэмэлт асуулт асууна. Хаанаас хариулах вэ? 3 номер.

Ж.Ганбат: Д.Батлут гишүүний асуултад хариулъя.

Засгийн газраас онцгой дэглэм тогтоосон өнгөрсөн оны 10 сарын 26-ны өдөр “Эрдэнэс Тавантолгой” компани хөрс хуулалт, олборлолтын гэрээнүүдийнхээ төлбөрийг нүүрсээр барагдуулдаг байсан. Энэ дээр нийтдээ 9 гэрээ байсан. Энэ 4-өөс 8 хувийн хөнгөлөлт өгдөг.

Энэ дээр үнийн хөнгөлөлтийн зөрүүнээс 2.7 тэрбум төгрөгийн алдагдал хүлээсэн гэдэг нь аудитын байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон байдалтай байсан.

Үүнийг 10 сарын 26-нд очоод зогсоосон. Бид төлбөрийг нь зогсоогоод нүүрсээр өгдөг гэрээнүүдийг нь яг тэр хөрс хуулалт, яг энэ гэрээт ажлын төлбөрийг нүүрсээс өгдөг байсныг нь бүрэн зогсоогоод төлбөрийг нь бид мөнгөөр өгдөг рүү шилжсэн байгаа.

Энэ дээр компаниудынхаа мэдээж үнийн хөнгөлөлтийн асуудлуудаа авдаг байсан. Сая би тоон мэдээллийг нь өгчихлөө.

Дахиж энэ дээр бид төлбөрийг нь ялангуяа өөрийнхөө үндсэн хөрс хуулалт, тэр өрөмдлөг, тэсэлгээтэй холбоотой төлбөрийг нь бүгдийг нь бид төгрөгөөр өгөөд хэвшүүлчихсэн. Үүнийг нь сар сард нь гүйцэтгэлийг нь хянаад өгөөд яваад байгаа. Ийм асуудлууд байна.

Хоёр дахь асуудал бол лабораторийн асуудал үнэхээр асуудалтай байна. Үнэхээр энэ дээр “Эрдэнэс Тавантолгой” компани хоёр цанхиасаа олборлолтоо хийж нүүрсээ борлуулж байгаа. Зүүн, баруун.

Ер нь бүх компаниуд зүүн дээрээс нүүрс авъя гэдэг ийм хүсэлт тавьдаг. Баруун руу орох газар олддоггүй. Баруун нь чанаргүй гэдэг ийм асуудал яригддаг.

Тэгэхээр бид энэ чанарын асуудал дээрээ анхаарч байгаа.

Нөгөө талдаа лабораторийн асуудлууд үүсээд байдаг. Бид өөрсдөө энд хувийн нэг компаниар лаборатори хийлгэдэг. Нөгөө худалдан авагч тал маань бас өөрсдөө лаборатори хийлгээд. Тэгээд лабораторийн дүгнэлтүүд нь зөрөөд байгаа. Тэгээд энэ лабораторийг хэрхэн цаашаа явуулах вэ гэдэг үнэхээр тулгамдчихсан асуудал. Энэ дээр бид ямар байдлаар явах вэ гэдэг.

Бид нэг юман дээр найдаад байгаа нь манай гаалийн лаборатори маань Бүгд Найрамдах Хятад Ард Улсын лабораторийн итгэмжлэлийг нь авчихсан. Энэ гаалийн лаборатори нь манай худалдан авагч тал Бүгд Найрамдах Хятад Ард Улсын лабораториудын шаардлагыг бүрэн хангаад ажиллана гэдэг л ийм итгэл найдвар дээр л байна л даа.

Нөгөө талдаа бид бас лабораториуд дээр тавьж байгаа шаардлагуудаа өндөрсгөж байна. Манайхны хүчин чадал хүрдэг, хүрдэггүй асуудлууд байна.

Тэгээд яах вэ, чанарын асуудлыг бид ялангуяа тэр Баруун Цанхийн асуудлыг л яаралтай шийдэх талд нь бид

үнэхээр анхаарч байна. Тэгэхгүй бол үнэхээр бид нараас авсан нүүрсээ, өмнө нь авсан нүүрсээ буцааж байсан ийм тохиолдлууд гарч байсан юм байна лээ. Чанарын шаардлага хангахгүй байгаа учраас нүүрсээ буцааж өгье гэдэг асуудлууд.

Тэгэхээр энэ дээр нь бид тодорхой юмнуудыг цаашдаа анхаарч хийх ийм шаардлагууд байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Д.Батлут гишүүн нэмэлт асуулт асууя.

Д.Батлут: Харин тийм.

Тэгэхээр бид ингээд дэвшил гаргах гэж байтал өөрсдөө лабораторийн хүчин чадлаасаа ч юм уу хамаараад ингээд асуудлууд үүсээд магадгүй хүндрэх нөхцөл байдал үүсэх вий дээ. Энэ дээр онцгой анхаараад гарц гаргалгаануудаа яаралтай гаргаж шийдэл гаргахгүй болохгүй шүү гэдгийг.

Хоёрдугаарт нь, тэр хөрс хуулалт хийсэн 9 гэрээ гэж байгаа. Тонн тутмыг нь хэдэн доллароор хийсэн юм бол. Тэрийгээ нэг тоогоор илэрхийлчхээч. 4-өөс 8 хувь л гээд байна. Ямар үнэ өртгөөс нь бодсоныг би тодорхой болгомоор байна.

Гуравдугаарт нь, энэ хувьцаа эзэмшигч нартаа ашгаа хуваах тухай асуудал.

Ер нь нэг зүйлийг л хэлье. Хөрөнгө оруулалт ч хийгдэх ёстой, хувьцаа эзэмшигчдийнхээ хувьцааг ногдол ашгийг олгодог байх ёстой шүү. Ингэж байж энэ компани чинь явах болохоос биш зөвхөн хөрөнгө оруулалтаа хийгээд дараа нь олгоно гэдэг хэлбэр чинь хамгийн буруу хэлбэр гэж харж байгаа. Зэрэг явж байж энэ ажил маань

иргэд тэр хувьцаа эзэмшигч нар чинь ч гэсэн тодорхой хэмжээгээр сэтгэл ханамжтай, үйлдвэр маань ч гэсэн цаашдаа урт удаан хугацаанд өгөөжөө өгч явах тийм боломж бололцоо бүрдэнэ.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Д.Батлут гишүүн та дараа нь хариулт хангалтгүй бол тодруулж асууж болно шүү. Хариулья. 3 номер. Ажлын хэсгийн 3 номер.

Ж.Ганбат: Энэ нөгөө гэрээт олборлосноосоо 9 гэрээг ихэнхийг нь тэр Баруун цанхиасаа өгдөг. Тэр нүүрс нь зарагддаггүй гээд бас нөгөө хөрс хуулалтын компаниуд нь санхүүгийн хувьд хүндэрчихсэн ийм байдалтай.

Яах вэ, яг ам нөхцөлтэйгөөр өгч байсан. Ам нөхцөлтэй өгч байсан гэрээнүүд жишээ нь 100-аас 110 ам.долларыг хамгийн сүүлд тэгж өгч байсан. Үүнээсээ жишээ нь 100 ам.доллороор өгч байлаа гэхэд үүнээсээ нэг 4-өөс доод 8 хувийн хөнгөлөлтийг доогуур өгдөг байсан. Ийм явж байсан юм билээ. Гэхдээ яах вэ тэр компаниудынх нь ярьж байгаагаар хамгийн муу Баруун цанхийнхаа нүүрсийг өгдөг байсан. Бид тэрийг нь зарж борлуулахад хүндрэлтэй байдал үүсдэг байсан гэдэг ийм тайлбар тавьж байгаа.

Хоёр дахь асуудал. Тантай санал нэг байна. Засгийн газар дээр ийм зарчим барьж байгаа. Яг тантай адилхан. Компани өөрөө ногдол ашиг хуваах эсэхээ шийддэг. Үүнийг ямар нэгэн улс төрийн зорилгоор болон Засгийн газар оролцохгүй байдлаар компани өөрсдөө яг энэ 18.4 хувь эзэмшиж байгаа иргэдийнхээ ногдол ашгийг нь өгдөг асуудлаа өөрсдөө шийдээ л гэдэг юм ярьж байгаа юм.

Ц.Цэрэнпунцаг: Д.Батлут гишүүн тодруулж асуух уу? Болсон уу? Г.Ганболд гишүүн асуултаа асууя.

Г.Ганболд: БЭТ-ийн хугацааг сунгахыг дэмжиж байна. Энэ хугацаанд маш их ахиц дэвшлүүд гарсан.

Тэгэхдээ бид ер нь энэ хуулиа өөрчлөөд 1991 оны Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хуулиар яваад нэг нийгэмд эргэлзээ төрүүлээд байхаар ер нь үүнтэйгээ цуг шинэ хууль оруулаад батлуулчихаад явмаар юм даа.

Энэ бол өөрөө ерөөсөө үндсэн зорилго нь бол Эрдэнэтийн 49 хувийн удирдлагыг нь авах гэж л хийсэн зүйл шүү дээ. Зөвхөн удирдлагыг нь л авах.

Тэгээд удирдлага авсны дараа энэ ерөөсөө дотор нь тийм онцгой дэглэм тогтоогоод өөр мөрдөгдөж байгаа юм байхгүй шүү дээ. Тийм ээ. Ж.Ганбат аа. Одоо юу гэдэг юм шууд тендер худалдан авалт хийж байгаа юм байхгүй, шууд хүмүүс худ авч байгаа юм байхгүй. Онцгой дэглэм тогтоосон гэхээр хүмүүс нэг тийм айхтар онцгой эрх мэдэлтэй хүмүүс байна гэж бодож байгаа боловч бүгд ингээд л төрийн хуулийн дагуу л явж байгаа.

Тэгээд үүнийг ер нь цаашдаа цэгцлээд явах нь зөв юм байна гэж бодож байгаа.

Ер нь Тавантолгой компани бол асар их ашигтай компани юм билээ. Бид өнгөрсөн хугацаанд том том төслүүдийг хэт их энэ компанийн хөрөнгөөр санхүүжүүлснээс болоод энэ компани өөрөө дампуурлын ирмэгт хүрчихсэн. Түүнээс өмнөх удирдлагуудыг нь бид айхтар тийм их муулаад байх ч зүйл байхгүй юм байна лээ гэж би өнгөрсөн

хугацаанд энэ нэг нүүрсний ажлын хэсэг гэж явж байхад харж байгаа юм.

Тэгээд энэ дээр би ерөөсөө хоёр, гуравхан зүйлд л ерөөсөө хамгийн гутамшигтай байгаа юм.

Нэгдүгээрт нь, ерөөсөө энэ мухар төмөр замыг шийдэхгүй бол энэ бол хамгийн том гутамшиг.

Бид наана нь нэг тэрбум 483 сая доллароор Бодиор зам аваачиж тавьчихаад цаанаа холбогдохгүй бол энэ өөрөө ямар ч үнэ цэнгүй төмөр зам. Хар үгээр ярих юм бид нарыг том гол дээр гүүр барилгүй хоёр талаас нь замаа тавьчихсан. Тэгээд давхиж очоод тэр голоор нөгөө салчингуудаар завиар гардаг. Яг түүн шиг тэнд 20 мянган машин чинь тэр гүүр, 7 километр төмөр замыг холбуулахгүй байх лобби хийгээд байгаа байхгүй юу.

Тэр холбогдчих юм бол 20 машин тэр хятадууд ч бай, Монголын ч бай тэр машинууд ажилгүй болно.

Тэгэхээр тэд нар Хятадын талаа лоббидоод энэ 7 километр төмөр зам ер нь холбохгүй юм билээ шүү дээ.

Тэгэхээр үүнийг яаралтай холбохгүй бол бид хайран наана нь өчнөөн их наяд, тэрбумаар ажил хийгээд бүтэхгүй байна.

Хоёрдугаарт нь, энэ үнэ тариф дээр би Тавантолгой дээр ганцхан зүйл ажиглаад байгаа нь манайх ерөөсөө улирлаар нь үнээ тогтоодог. Улирлаар. Нэг улирал ингээд л тогтмол нэг үнээр ингээд Тавантолгойн нүүрс өгч байхад Хятадад цаана нь өдөр болгон өөрчлөгдчихдөг.

Энд нэг 70 доллар өгч байхад цаана нь 500-аад доллар болчихсон

байхад бид нөгөөдхөөрөө л ингээд л улирал нөгөө үнээ бариад л явж байна. Тэр дунд нь нөгөө тээврийн зардал нь ингээд өдөр болгон савлаад явдаг.

Тэгэхээр зэрэг би Тавантолгойг энэ нүүрснийхээ үнийг маш богинохон хугацаагаар өөрчилж явдаг ийм юм руу орох зайлшгүй шаардлагатай юм билээ гэж.

Хамгийн нэг ноцтой зүйл өнгөрсөн хугацаанд бид тэр 7 сая орчим тонн нүүрсийг 9.5 доллароор л зарсан юм байна лээ л дээ. Нөгөө эрчим хүчний нүүрс, исэлдсэн нүүрс гэдэг нэрээр.

Тэгэхээр энэ дээр лабораторийн асуудал маш чухал байгаа юм. Одоо бид чинь ингээд уурхайн том амыг чинь мөргөцгөөр нь л лабораторио шинжлээд л энэ нь эрчим хүч байна, энэ нь исэлдсэн байна, энэ нь хагас кокс, коксжих гээд. Гэтэл Хятад чинь бараг 6, 8 ангилалтай байна уу? Яг Хятадын тэр ангилал руу оруулаад лаборатори дээрээ бид эндээ маш сайн шинжилгээ хийж энэ явахгүй бол би бол хамгийн ноцтой зүйл бол энэ эрчим хүчний болон исэлдсэн нүүрс гэдэг зүйлээр 9, 10 доллароор гэрээ хийгээд өгч байгаа дээр би хамгийн их эргэлзэж байгаа. Тэгээд энэ жаахан ноцтой юм байна лээ.

Ер нь түрүүний С.Ганбаатар гишүүдийн хэлж байгаа үнэн. Одоо “Эрдэнэс Тавантолгой” гэхэд байна шүү дээ, зөвхөн нэг компанитай зүгээр тоног төхөөрөмж худалдаж авах 940 тэрбум төгрөгийн гэрээ хийж байгаа шүү дээ. Улсын төсөв чинь ерөөсөө хөрөнгө оруулалт нь 1.5 их наяд. Тэгэхэд зүгээр нэг компанитай л.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгээс 3 номер хариулья.

Ж.Ганбат: Г.Ганболд гишүүний хэлж байгаа юмнууд бодитоор тэнд үүсчихсэн байсан.

Одоо яах вэ, бид тэрийг цэгцлэх гээд үзэж байна. Яах вэ, тэр үнийн хувьд 2022 онд нийтдээ нэг 603 сая доллар урьдчилаад авчихсан юм билээ.

Тэгээд энэ урьдчилгаа төлбөр. Үүнтэй холбогдуулан үнээ улирлаар тогтоодог. Бид өмнө нь байгуулчихсан ам нөхцөлтэйг нь өөрчлөөд. Түүрүүн би нэг тоо хэлсэн. Ам нөхцөлтэй гэрээнүүдийг бүгдийг нь хил нөхцөл рүү шилжүүлэх ийм шаардлагыг тавиад яах вэ, зарим гэрээнүүд нь амжилттай бид хэрэгжүүлсэн л дээ.

Өмнө байгуулчихсан гэрээнүүдийн цаашдын нөхцөлийг нь өөрчлөхөд хүнд юм байна лээ.

Зүгээр яах вэ, яг үнэ тооцож байгаа аргачлалыг бид сараар тооцдог ядаж больё гэдэг ийм хүсэлтийг худалдан авагч нарт тавьж үзэж байгаа. Үнэ бол урд талдаа хэлбэлзэлтэй байгаа учраас энэ дээрээ ингэе гэдэг.

Нөгөө талдаа саяын тэр 1.2 их наядаас 900 гаруй тэрбум төгрөг дээр нь нэг компани тендерт авчихсан байгаа. Энэ тендерээр тоног төхөөрөмж дээр нь өмнө нь зарлагдаад, дүгнээд энэ тоног төхөөрөмж нь ороод эхэлчихсэн.

Бид үүнийг цаашаа яаж ашиглах вэ гээд тооцоог нь хийгээд үзэхээр алдагдалтай. Бид үүнийг нь яаж цаашаа ашиглах вэ гэдэг ийм асуудал хүртэл яригдаж байна л даа.

Гэхдээ бид нэгэнт төрийн өмчийн хөрөнгө зараад одоо зарим тэр 900 хэдэн тэрбум төгрөгийн үнэлгээтэй тоног төхөөрөмж нийлүүлсэн компанийн

оруулаад ирчихсэн тоног төхөөрөмжийг шаардлага хангахгүй гээд бид буцаах шийдвэр гаргаад буцаачихсан ийм тохиолдол байна.

Шаардлага хангаж байгааг нь аваад бид яаж үүнийг ашигтай ажиллуулах вэ, яаж бид үүнийг ядаж гаргасан хөрөнгөө нөхөх вэ гэдэг дээр одоо ингээд ажиллая гэхээр өмнөх төлөвлөлтөө буруу хийдэг. Нөгөө тендерүүд нь далд хэлбэртэй явдаг. Төсөв нь батлагдахдаа мөнгөн хөрөнгийн хувьд жишээ нь алдагдалтай баталдаг ийм асуудлууд байсан.

Яах вэ энэ бүгдийг л цэгцлээд. Одоо нэгэнт өмнө нь хувийн хэвшилтэй гэрээ байгуулаад тендерээ дүгнэчихсэн юмыг бид зогсоогоод яах вэ гэдэг асуудлууд хүртэл яригдаж л байна л даа.

Тэгэхээр бид аль болох энэ компанийн хохирол багатай. Тэгэхээр яах вэ үр ашигтай явуулах энэ талд нь түлхүү байгаа.

Нөгөө талдаа яах вэ олон жил яг ний нуугүй ярихад 12, 13 жил ам нөхцөлөөр явчихсан. Одоо хил нөхцөл, бирж рүү шилжихэд манай Бүгд Найрамдах Хятад Ард Улсын худалдан авагч нар бүгд алга ташаад хүлээж авахгүй байгаа.

Энэ дээр бид маш их юмнуудтай тулж байгаа. Өнөөдрийг хүртэл асуудлууд үүсэж л байна. Тэгэхдээ эхнээс нь цэгцлээд л явж байгаа.

Тэгэхээр бид ер нь яаралтай энэ биржийн арилжаагаа жигдлэх асуудал дээр онцгой анхаарч байна. Бирж жигдрээд бүх нүүрсийг бирж дээр гараад эхлэх юм бол энэ нүүрс тойрсон далд юмнууд ер нь арилчихна. Эргэлзээ тайлагдана, ил тод, нээлттэй болно гэдэг

ийм байр суурийг баримтлан ажиллаж байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Г.Ганболд гишүүн нэмэлт хүсэлт асууя.

Г.Ганболд: Асуулт асуухгүй. Санал хэлнэ.

Одоо нүүрсээр гэрээ хийхгүй л байх нь л хамгийн чухал юм билээ.

Тэртээ тэргүй бэлэн мөнгөөр авъя гээд дүүрэн компаниуд очерлоод зогсож байхад заавал чамд хөнгөлөлттэй өгнө гээд нүүрсээ. Урьдчилгаа төлбөрөө өгөөд ингээд зүгээр ямар нэгэн хөнгөлөлтгүй авъя гэсэн өчнөөн компани байхад л тэгээд Чалко гээд компани.

Тэр бол арга байхгүй. Тухайн үедээ 350 сая. Тэр жишиг рүү оруулах гээд л тэгээд л ерөөсөө нэг ийм байдлаар явсаар байгаад энэ компани нэг жаахан хүнд байдалд оруулсан юм билээ.

Тэгэхээр одоо бол энэ тэртээ тэргүйгээр хангалттай зах зээл байхад нүүрсээр гэрээ хийдгийг зогсоогоод явах юм бол энэ Тавантолгой компани ашигтай ажиллаад явах бүрэн боломжтой юм билээ.

Тэгэхээр би яг одоо энэ БЭТ-ийн хугацааг сунгаад 6 сарын хугацаанд.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: О.Цогтгэрэл гишүүн асуултаа асууя.

О.Цогтгэрэл: “Эрдэнэс Тавантолгой” компанид бүрэн эрхт төлөөлөгчийг сунгах тухай асуудал.

Энэ дээр бүгдээрээ л сайн сайхан болсныг нь л гайхацгааж л байна л даа.

Мэдээж тодорхой хэмжээний ахиц дэвшил гарсан байгааг бас үгүйсгэхгүй.

Гэхдээ энэ чинь өөрөө бизнесийн ажил. Дандаа тоогоор явдаг. Энэ тоо одоо ингээд баахан тайлан нь, ингээд сайн мэдээнүүд нь ороод ирчихсэн л байна л даа.

Тэгэхдээ бизнес чинь өөрөө бас цаанаа хэлтэй. Нягтлан бодохтой. Тэрийг нь хөндлөнгийн байгууллага баталгаажуулдаг, аудит хийдэг. Болж өгвөл ийм том хэмжээний компанийг, ийм том хэмжээний асуудал хуримтлагдсан компанийг олон улсын аудитын байгууллага баталгаажуулсан тайланг бид авч үүнийг үнэн зөв гэж л үзэх ёстой.

Төрийн аливаа байгууллагуудын тайлан орж ирэхэд яг ингээд л нэг гоёчилчихсон. Үүний цаана асуудал хуримтлагдаад л явдаг.

Тэгэхээр өнгөрсөн хугацаанд одоо чинь ингээд Та нар чинь он дамнаад ажиллачихлаа. 2 сарын 15-нд бүх тайлан тооцоо 2022 оных гарчихсан.

Тэгэхээр “Эрдэнэс Тавантолгой” компанийн тайланд ямар байгууллага аудит хийсэн юм? Энд олон улсын байгууллага, олон улсын компани ч юм уу аудит хийсэн нь энэ бичиг баримт мөн үү, биш үү?

Энэ аудитынхаа дүгнэлтийг энэ дээр би тийм тоо баримт үзсэнгүй л дээ. Тийм зүйд л итгэхгүй бол бид асуудлыг гоёчлоод өөрснөө хэрэгтэй тоонуудаа сугалж аваад өөрснөө тайлбарлачихдаг. Дараа нь цаана нь асуудал хуримтлагддаг гэдгийг л тэр тусмаа энэ төртэй холбоотой байгууллагууд дээр асар олон зүйл ярьдаг. Энэ дээр нэг хариулт тайлбар өгөөч.

Хоёрдугаарт нь, энэ чинь ердийн горимоор ч явсан байна уу, бүрэн эрхт төлөөлөгч “БЭТ” томилогдоод явсан ч байна уу цаана нь хуулийн үйлчлэл нь өөр байх.

Тэгэхээр магадгүй энэ дотор олон давуу эрх эдэлдэг биз. Яг “БЭТ” томилогдсоноос хойш хэчнээн гэрээг Төрийн худалдан авалтын хуулийн дагуу, тендерийн хуулийн дагуу биш шууд хэчнээн гэрээ, Та нар яг ямар ямар гэрээ хийв? Магадгүй энэ дотор тэр оффтейк гэрээ биш гэхэд бас нэлээн олон гэрээ. Ийм гэрээнүүдийг шууд хийх гэж бусад хуулийн үйлчлэлүүдээс давуулж хийх гэж Та нар бас мэдээж “БЭТ” томилогдож байгаа байх бодвол.

Тэгэхээр энэ хоёр асуултад хариулт өгөөч. Аудитын тухай, Та нар “БЭТ” томилогдсоноос хойш тендерийн хуульгүйгээр, тендерийн хуулийн шалгаруулалтгүйгээр хэчнээн гэрээ хийсэн бэ? Ямар ямар том дүнтэй гэрээнүүд хийгдсэн бэ? Дотоодын тэр нүүрс хуулгалт олон зүйлээс эхлүүлээд.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн 3 номер хариулья.

Ж.Ганбат: О.Цогтгэрэл гишүүний асуултад хариулья.

Хоёр дахь асуултыг нь би эхлээд товчхон хариулчихъя.

Энэ компани дээр яг онцгой дэглэм тогтоох үед зүгээр нууц гэдэг ангилалд оруулж байгаа шууд гэрээ байгуулдаг байсан.

Хоёр дахь нь, өмнө нь гэрээ гүйцэтгэсэн компанийн эрх ашгийн үүднээс шулуухан хэлэхэд дараа нь тендерт яасан компани гэрээ нь

байгуулахгүй тэрийг нь ингээд хуулиуд хүчингүй болгочихдог ийм байсан.

Бид үүнийг зогсоосон. Бид ямар нэгэн компанитай шууд гэрээ байгуулаагүй. Бид байгуулахгүй гэдгийг ил тод зарлаж байгаа. Бид ямар нэгэн гэрээг шууд байгуулаагүй.

Одоо хугацаа нь дуусгавар болсон 3 жилийн хугацаатай зарласан тэр хөрс хуулалтын олборлолтын тендерийг сая 3 сард зарлаад дүгнэсэн. Тэр нь тэгээд маргаан гараад тэр асуудал хянагдаад явж байгаа.

Ер нь энэ компани дээр бид нууц гэдэг байдалтай юм хийх шалтгаан, шаардлага байхгүй. Нууцад хамааруулж ажил гүйцэтгэх шаардлага байхгүй гэдэг ийм дүгнэлтээр гаргаад цаашдаа юмнуудаа ажиллаж байгаа. Ямар нэгэн байдлаар бид ямар нэгэн гэрээг шууд хийгээгүй.

Нөгөө талдаа бид тэр борлуулалтын, олборлолтын гэрээнүүдийг, хугацаа нь дууссан гэрээнүүдийг дуусгавар болгоод бид цаашаа сунгахгүйгээр хугацаанд болоогүй гэрээнүүдийг хил нөхцөл рүү шилжүүлэх байдлаар худалдан авагч нартайгаа хэлцэл хийгээд ингээд явж байгаа.

Нийтдээ уурхайн ам нөхцөлтэй 103-ын 33 гэрээнээс бид 87 гэрээ нь хугацаа нь дуусаагүй байсныг хил нөхцөл буюу биржийн үнэ рүү шилжүүлээд 87 гэрээг нь шилжүүлчихсэн. Хугацаа нь тэр оффтейк гэрээн дээр нийтдээ 4 гэрээ. Тэгээд дэд дотроо 38 гэрээтэй байсан. Үүний хугацааг нь дуусгавар болсныг би дахин сунгаагүй.

Одоо ганцхан гэрээ жишээ нь Тавантолгой, Гашуунсухайт төмөр зам

дээр үлдчихсэн. Энэ гэрээний хугацаа нь 2024 оны 12 сард дуусах юм билээ. Богд хаан төмөр замыг бүрэн зогсоочихсон.

Нүүрс баяжуулах үйлдвэр дээр нэг гэрээ байгаа. Газрын тосны дамжуулах хоолой дээр нэг гэрээ байгаа.

Бид энэ дээр бас нүүрсээр төлбөрийг нь хийх гэрээн дээр бас хэлцэлд ороод тодорхой хэмжээгээр бас бид төлбөрийг нь төгрөгөөр хийнэ гэдэг ийм байр суурийг баримтлаад худалдан авагчийг нь гэрээ гүйцэтгэгч компанитай хэлцэлд ороод байгаа. Ийм байна.

Аудитын хувьд Үндэсний аудитын газраас гэрээтэй “Гроут Финанс” /Growth Finance Audit LLC/ гэдэг компани аудит хийгээд дууссан. Үүнийг нь эцэслээд аудитын тайлан нь энэ долоо хоногийн сүүлээр дуусаад гар хөлийн үсэг зурагдаад дуусаж байгаа. Энэ тайлан дуусангуут бид аудитлагдсан өнгөрсөн оныхоо тайланг ТУЗ-даа танилцуулж байгаа.

Өмнө нь 2 жил энэ компани дээр аудит хийж байсан ийм компани юм бмлээ.

Бид Засгийн газар чиглэл өгсний дагуу олон улсын нээлттэй сонгон шалгаруулалт зарлаад олон улсын хөндлөнгийн аудит оруулах гэж үзсэн.

Олон улсын тэр хүлээн зөвшөөрөгдсөн аудитын компаниуд манай Эрдэнэс Тавантолгой компани руу нүүрсний гэх энэ асуудалтай холбогдуулан орохоосоо татгалзаж байгаа ийм байдлууд байгаа.

Бид ямар нэгэн байдлаар орооч ээ гэдэг байдлаар хүсэлтийг удаа дараа тавьж урьж байгаа.

Нөхдүүд ямар асуудал тавьж байна гэхээр 2023 оны чинь үйл ажиллагаан дээр бид аудит ороод та нарын хийж байгаа энэ асуудал дээр чинь зөвлөмж өгөөд хамтраад ажиллая гэдэг байр суурийг баримтлаад. Түүнээс биш өмнөх асуудал дээр бид оролцмооргүй байна гэдэг ийм байр суурь барьж.

Гэхдээ бид ямар нэгэн байдлаар олон улсын аудитыг энэ компани дээр оруулаад эхлэлтийн цэгээ зөв хатгаад цаашаа явах нь зүйтэй юм гэдэг байр суурийг баримталж байгаа.

Ц.Цэрэнпунцаг: О.Цогтгэрэл гишүүн нэмэлт асуулт асууя. О.Цогтгэрэл гишүүний микрофоныг нээе дээ.

О.Цогтгэрэл: Тэгэхээр өмнө нь 2 жил аудит хийсэн компани одоо танай өнөө жилийг хийж байгаа юм байна л даа.

Тэгэхээр өмнө нь энэ их будилаан дотор хаана яваад, ямар дүгнэлт гаргаад байсан компани юм. Тэр компаниар одоо дахиад энэ будилааны чинь дараа аудит хийлгэчхээд тэр нь дотоодын компани бололтой юм байна. Ингэж хийлгэчхээд суухаар энэ тайланд тэгээд дахиад хүн итгэх арга байх уу?

Ноднин уржнан, хоёр, гурван жилийн аудит хийсэн компани юм байна шүү дээ. Үүнийг олон улсын аудитын компаниар л заавал хийлгэх ёстой байх.

Хоёрдугаарт нь, тэгэхээр та борлуулалтын биш мөртлөө дотоод үйл ажиллагааны ямарваа нэгэн шууд гэрээ хийгээгүй гэж байна. Хийх шаардлагагүй гэж байна.

Тэгэхээр “Эрдэнэс Тавантолгой” дээр БЭТ үргэлжлэх ямар шаардлага байгаа юм? Төрийн бусад худалдан

авалтын хууль, шийдвэрүүдийн дагуу ажил явдаг л юм бол. Одоо БЭТ сунгаж яах юм? Та нарт хэрэгцээгүй юм байна шүү дээ. Та нарт нэмэлт ямарваа нэгэн ажлыг шуурхай явуулна, тэгнэ ингэнэ, ингэхийн тулд энэ хуулийг тойрѐ гэдэг шаардлага байхгүй л юм байна шүү дээ.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн 3 номер хариулья.

Ж.Ганбат: Аудит дээр бид яг тантай адилхан байр суурьтай. Бид олон улсын аудит заавал оруулж байж тоон мэдээллүүдийг үнэн зөв гэдгийг нь баталгаажуулж байж цаашаа явна гэдэг дээр хатуу байр суурьтай байгаа.

Бид олон улсын аудиттай удаа дараа хэлцэлд орсон. Үнэхээр тэр нүүрсний гэх асуудалтай холбогдуулан танай энэ асуудал руу өөрсдийн нэр хүндийн асуудал энэ тэр. Цаад талын толгой төв оффисоосоо асуухаар татгалзаад байгаа юм билээ.

Тэр өмнө орж байсан аудитын компанийг Үндэсний аудитын газраас манайх руу оруулсан. Бид 10 сарын 26-нд томилогдож очсон. 10 сарын 26-нд энэ компанид тэр аудитын компаниуд үйлчилгээ явуулж байсан.

Бид Үндэсний аудит Улсын Их Хурлын харьяа нөгөө хараат бус байдал гээд нэгэнт орсон юман дээр нь юм хэлээгүй ингээд дууссан.

Бид ямар ч гэсэн олон улсын аудитыг оруулаад “Эрнст энд Янг” /Ernst & Young/ компанитай бид хэлцэлд орж байгаа. Манай дээр орооч ээ гэдэг байдлаар дүгнэлтээ гаргуулаад энэ тайлан баланс, тоон мэдээлэл, энэ компанийн мэдээллийг үнэн зөв гэдгийг нь баталгаажуулаад.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Ингээд сүүлд нь Д.Амарбаясгалан дарга аа, хариулт хангалтгүй байвал та тодруулж асууж асуух уу?

Д.Амарбаясгалан сайд та нэмээд хариулчих.

Д.Амарбаясгалан: О.Цогтгэрэл гишүүний асуултад хариулья.

Харин энэ олон будилааныг арилгах гээд Засгийн газраас бүрэн эрхт төлөөлөгч томилон ажиллуулсны үр дүнгээр борлуулсан нүүрсний хэмжээ 4.1 дахин, тээврийн хэмжээ 3.9 дахин, экспорт 2 дахин, орлого нь 3.9 дахин олборлолт нь 2.7 дахин тус тус өссөн.

Өнгөрсөн оны сүүлийн нэгхэн улирлын хэмжээнд 500 сая доллар төвлөрүүлэх даалгавраа 416.6 сая ам.долларыг төвлөрүүлж, өнөөдрийн байдлаар Монголбанк 3.7 их наядын нөөцтэй болох нөхцөлд ихээхэн хувь нэмрээ оруулсан гэж нэгдүгээрт үзэж байгаа юм.

Хоёрдугаарт, “Эрдэнэс Тавантолгой” зэрэг томоохон компаниуд нь улс төрөөс болон аль нэг өнцгөөс хараат бус байх ёстой гэдэг энэ зарчмыг Засгийн газрын зүгээс баримталж ажиллаж байна.

Өнөөдөр ердийн горимоор шууд гүйцэтгэх захиралд томилоод ажиллахад энэ богино хугацаанд урьд өмнө нь давтагдаж байсан алдааг засах бүрэн нөхцөл боломж бүрдсэнгүй гэж Засгийн газрын зүгээс үзэж байна.

Олон улсын аудитын байгууллагыг оруулж бүх үйл

ажиллагаанд нэгдүгээрт нь аудит хийлгэх.

Хоёрдугаарт, эрх зүйн орчныг нь сайжруулаад улс төрөөс хараат бусаар энэ гүйцэтгэх захирал томилогдон ажилладаг болох нөхцөлийг бүрдүүлэх.

Гуравдугаарт, болж өгвөл энэ аудитын тайлан гарсны үндсэн дээрээс олон улсын менежментийн компаниуд, менежментийн багууд орж ирж ажиллах нөхцөл нь бүрдэх юм бол энэ үр дүнд бодитой хүрэх юм гэж Засгийн газрын зүгээс үзсэн байгаа гэдгийг бас Та бүхэндээ хэлмээр байна.

Тэр үүднээс Засгийн газрын зүгээс бүрэн эрхт төлөөлөгчийн хугацааг сунгаж ажиллая. Энэ хугацаандаа нэгдүгээрт Биржийн хууль хэрэгжиж байгаа. Биржээр худалдаалж байгаа үйл ажиллагаагаа жигдрүүлчихье.

Хоёрдугаарт, урьд өмнө нь тээврийн 90 гаруй хувь нь манай урд хөршөөс хамааралтай томоохон нүүрсний худалдан авагч нар өөрсдөө тээврээ зохицуулж байсан бол үүнийг дотооддоо бүрэн тээвэрлэлтээ зохион байгуулдаг болъё. Тэрнээс олж байгаа татварын орлогыг нэмэгдүүлэх бодлогоо хэрэгжүүлбэ гэсэн ийм алхмуудыг Хятадын талтайгаа ч тохирох цаг хугацааны хэрэгцээ шаардлагууд гарчхаж байгаа юм.

Тэгэхээр эдгээрийг л ажил хэрэг болгох үүднээс бүрэн эрхт төлөөлөгчийн хугацааг сунгаж ажиллуулъя гэдэг энэ саналыг оруулж байгаа юм.

Өнгөрсөн 6 сарын хугацаанд бүрэн эрхт төлөөлөгч томилогдсоноос хойш “Эрдэнэс Тавантолгой” компанид ямар нэгэн байдлаар нөлөөлөл үзүүлэх

гэсэн улс төрчид, эсвэл аж ахуйн нэгжүүд өнөөдрийг хүртэл гарсангүй.

Энэ бол маш сайн үзүүлэлт.

Магадгүй үүнийг өөрчлөөд ердийн горимоор өөр нэг гүйцэтгэх захиралд томилогдоод явахад бас янз янзын нөлөөлөлд автчих, дарамтад өртчих нөхцөлүүд өнөөдөр нээлттэй хэвээрээ байгаа учраас энэ бүгдийг л нэгмөсөн арилгая, байхгүй болгоё л гэдэг ийм зорилгыг агуулж байгаа юм.

Ц.Цэрэнпунцаг: Гишүүд асуулт асууж, санал хэлж дууслаа.

Тэгээд Д.Амарбаясгалан сайд аа, танд 04 сарын 14-нд Засгийн газраас ирүүлсэн санал байгаа.

Энэ тогтоолын төслийг өргөн мэдүүлэх хэлбэрээр. Үүнийгээ хууль журмынх нь дагуу яаралтай татаж аваарай.

Дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийг баримталж хэлэлцэж байгаа учраас 04 сарын 14-нд ирүүлсэн саналыг бид Байнгын хороогоор хэлэлцэх боломжгүй байгаа шүү.

Ингээд санал хураалт явуулъя.

Монгол Улсын Засгийн газраас ирүүлсэн “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанид тогтоосон онцгой дэглэмийн хугацааг сунгах саналыг дэмжбэ гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/ Гишүүд анхааралтай байгаарай.

Гишүүдийн 68.4 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Мөн протоколд Н.Наранбаатар гишүүнийг дэмжсэнээр. Орчихсон уу. Тийм байна.

68.4 хувиар дэмжиж, санал дэмжигдлээ.

Д.Батлут гишүүн ээ, сууж байгаарай. Одоо нэг санал байгаа шүү.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсгийг үндэслэн Байнгын хорооноос боловруулсан “Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүн, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга Т.Энхтүвшин уншиж танилцуулна.

Т.Энхтүвшин гишүүний микрофоныг нээе дээ.

Т.Энхтүвшин: Монгол Улсын Их Хурлын тогтоол.

“Онцгой дэг дэглэмийн хугацааг сунгах тухай”

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1, 93.2 дахь хэсэг, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газрын эрх олгох тухай хуулийн 3 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Нүүрсийг биржээр дамжуулан хил нөхцөлөөр борлуулах үйл ажиллагааг тогтворжуулах, гадаад валютын орох урсгал, нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанид тогтоосон онцгой дэглэмийн хугацааг 6 сараар сунгасугай.

2.“Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанид тогтоосон онцгой дэглэмийн хугацаанд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газарт эрх олгох тухай хуулийн 2 дугаар зүйлд заасан асуудлын хүрээнд шаардлагатай арга хэмжээг авч онцгой дэглэм, түүний хэрэгжилтийн явцыг танилцуулж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-д даалгасугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга Т.Энхтүвшин нарт үүрэг болгосугай.

4.Энэ тогтоолыг 2023 оны 04 сарын 26-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Ийм тогтоолын төсөл байж байна.

Ц.Цэрэнпунцаг: Тогтоолын төсөлтэй холбоотой саналтай гишүүд байна уу? Алга байна.

Ингээд тогтоолын төслөөр санал хураалт явуулъя.

“Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 57.9 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Ингээд санал хураалт явуулж дууслаа.

Тогтоолын төслийг хэлэлцсэн талаар Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир гишүүн танилцуулна.

Байнгын хороодын хамтарсан хуралдаан үүгээр өндөрлөлөө. Гишүүд Та бүхэндээ баярлалаа.

Хуралдаан 1 цаг 42 минут үргэлжилж, 13 цаг 05 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД